



Хүчтэй. Хамтдаа.

Агуулга

ТУЗ-ийн даргын илтгэл	5
2016 он тоогоор	7
2016 оны онцлох үйл явдал	11
Гүйцэтгэлийн тойм	15
Компанийн түүх	17
Эрхэм зорилго, алсын хараа	18
Мөрдөх зарчим болон давуу шинж чанар	19
Эдийн засгийн байдал, санхүүгийн салбар үзүүлэлт	23
Үнэлгээ	27
Компанийн бүтэц	30
Үйл ажиллагааны тайлан болон удирдлагын шинжилгээ	35
Томоохон хэлцэл	38
Санхүүгийн үр дүн ба шинжилгээ	41
Хөрөнгө оруулалт болон зээлийн багц	43
Дараачийн алхам	47
Тайлангийн дараа өрнөсөн үйл явдал	47
Охин компаниудын тайлан	48
Тусдаа санхүүгийн тайлан	57
Нэгтгэсэн санхүүгийн тайлан	62



ТУЗ-ийн даргын илтгэл

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдээ!

2016 онд Монголын эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдал амаргүй байсан ч Ард Санхүүгийн Нэгдлийн хамт олны хичээл зүтгэл, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэмжлэг, оролцоо болон, хамгийн гол нь, бидэнд итгэл хүлээлгэсэн хувьцаа эзэмшигчид та бүхний хүчээр бид олон сайхан ололт амжилтанд хүрлээ.

ТУЗ-ийн ээлжит хурлыг бид гурван удаа зохион байгуулсан бөгөөд эдгээр хурлуудад удирдлагын баг болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын гишүүд бэлтгэлээ сайн ханган оролцжээ.

4 сард бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулсан ба хувьцаа эзэмшигчид биднийг Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг даалгасан юм.

БидиОү Аудитын компани нь сүүлийн гурван жилийн турш манай санхүүгийн тайлангийн аудитыг маш сайн хийж ирсэн тул бид 2016 оны тайланд аудит хийх байгууллагаар мөн тэднийг сонгосон гэдгээ мэдэгдэхэд таатай байна.

ТУЗ-ийн үндсэн үүрэг нь Гүйцэтгэх захиралд зөвлөгөө, чиглэл өгөхөд оршино. Бид Хууль, эрх зүйн нийцэл эрхэлсэн захирал, Эрсдэл эрхэлсэн захирал гэх ТУЗ-д шууд тайлагнах үүрэгтэй хоёр шинэ албан тушаалыг бий болгох шийдвэрийг гаргаж, үүний дагуу боловсон хүчнийг шалгаруулж авсан юм. Ард Санхүүгийн Нэгдлийн Дотоод аудитор ажилдаа орсон бол бид ТУЗ-ийн нарийн бичгийн даргын шинэ орон тоог бий болгон ажиллалаа.

Заг ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б. Нэмэхбаатар өөрийн эзэмшлийн хувьцаагаа Техник Технологийн Их Сургуулийн (цаашид ТТДС гэх)-ийн хувьцаагаар сольсноор манай ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс гарах болсон юм. Б. Нэмэхбаатар нь манай ТУЗ-д 2012 оноос хойш ажилласан билээ. Ард Санхүүгийн Нэгдлийн хөгжилд оруулсан түүний хувь нэмэрт талархал илэрхийлэхийн сацуу ирээдүйн ажилд нь амжилт хүсэе.

Монголын Алт (МАК) ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Цэлмүүн нь 2013 оноос хойш манай ТУЗ-д ажиллаж ирсэн ба ашиг сонирхлын зөрчлийн улмаас ТУЗ-өөс гарах хүсэлтээ өгсөн юм. Харин өөрийн оронд Монголын Алт (МАК) ХХК-ийн Хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлагын газрын захирал

Ц.Ариунтөгсийг нэр дэвшүүлсэн. Уг асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин Урамшуулал, Нэр дэвшүүлэх Хороо нь энэхүү асуудлыг холбогдох журмын дагуу 2017 онд эцсийн байдлаар шийдэхээр ажиллаж байна.

Хишиг Арвин Индастриал ХХК-ийн захирал Х. Батхишиг нь Монгол Шуудангийн хувьцааны арилжааны дараа манай компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч болсон тул манай ТУЗ-д уригдан нэгдсэн билээ.

Бид цаашид ч ТУЗ-д зарим өөрчлөлтүүд орно гэсэн хүлээлттэй байна. Учир нь, өнөөгийн бидний хөгжлийн шатанд ТУЗ нь илүү хурдан шуурхай ажиллах чадвартай болж, үр бүтээмжээ дээшлүүлэх шаардлагатай гэж бид үзэж байгаа.

ТУЗ нь хэд хэдэн стратегийн хэлцлийг хянан үзэж, санал бодлоо хэлж, шийдэл, чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгсөн билээ. 1 сард удирдлагын багаас Монгол Шуудангийн түүхэн хувьчлалд оролцох саналаа ТУЗ-д хүргүүлсэн юм. ТУЗ болон удирдлагын баг өндөр шуурхай харилцан уялдаатай ажилласны үр дүнд бид Монгол Шууданд хувийн хэвшлийн хамгийн том төлөөлөл болж чадлаа. Оны дундуур бид өөрийн эзэмшлийн хувийг нэмэхийг зөвшөөрсөн бөгөөд ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл нь Хишиг Арвин Индастриал ХХК-ас Монгол Шуудангийн 13 хувийг худалдан авч, 30.56 хувьтай болсон.

Сүүлийн хэдэн жилийн турш хэлэлцсэний эцэст бид ТТДС-ийн арилжааг гүйцэтгэж, урт хугацааны зээл, үл хөдлөх хөрөнгө болон өөрийн хувьцааг оролцуулсан наймааг хийсэн юм. Энэхүү хэлцлийг байгуулахад шантралгүй ажилласан удирдлагын багийн зүтгэлийг онцлон дурдах нь зүйтэй билээ.

Зээлийн үйлчилгээ үзүүлдэг Ард Кредит ББСБ болон брокер, дилер, хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Ард Секюритиз ҮЦК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрлийг ТУЗ-өөс тус бүр олгосон юм. Бид мөн Ард Менежмент, Ард Лайф компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэхээр шийдвэрлэж ажилласан билээ. Ард Даатгалд бид 27.72 хувийг нэмж авсан бол өдгөө Ард Кредитын 80.7 хувийг эзэмшиж байна. Энэ бүх шинэ хөрөнгө оруулалт, хэлцлийг бид дотоод эх үүсвэрээр санхүүжүүлсэн бөгөөд манай хувьцаа эзэмшигчдэдээ хамгийн бага ачаалалтайгаар гүйцэтгэж чадсан юм.

Ард Санхүүгийн Нэгдлийг Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй болгох нь манай ТУЗ-ийн эн тэргүүний зорилт хэвээр байна. Бид удирдлагын багаас үүнтэй холбоотой төлөвлөгөө гаргахыг хүссэн ба үүний дараа ТУЗ-өөс уг төлөвлөгөөг батлаж өгсөн юм. Тус төлөвлөгөөний дагуу Хөрөнгө Оруулагч Үндэстэн болон Жинст Увсыг нэгтгэсний дараа Ард Санхүүгийн Нэгдэл Хөрөнгө Оруулагч Үндэстэнтэй урвуу нэгдэл хийж олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхлэхээр тооцоолсон болно.

Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн гаргасан хувьцааны 10 хувийг 2020 он хүртэл ТУЗ болон удирдлагын багийн гүйцэтгэл дээр тулгуурлан олгохоор болсон билээ. Бид энэхүү төлөвлөгөөг 2016 оны үр дүнгээс эхлэн олгож эхлээд байна. ТУЗ-ийн гишүүн бүр 2 жил дарааллан өөрийнхөө үнэлгээг хийсэн ба ТУЗ уг тооцоотой танилцсаны дараа гишүүн тус бүрээр ногдох хувьцааг тодорхойлох болно.

Компани нь олны анхаарлын төвд байсаар байгаа бөгөөд манай хувьцаа эзэмшигчдийн тоо өссөөр оны эцэс гэхэд 3,000 гаруйд хүрлээ (гэвч зөвхөн 502 хувьцаа эзэмшигч бүртгүүлж амжсан байна). Өнгөрсөн жил 14.2 орчим тэрбум төгрөгийн Ард Холдингсын хувьцааны арилжаа хийгдсэн байна. Үүгээрээ бид Монголын аливаа нэг компанийн хувьцааны арилжааны дээд

амжилтыг тогтоосон ба энэ хандлагыг үргэлжлүүлэн хадгалахаар шамдан ажиллах болно. Одоогийн байдлаар манай компанийн томоохон хувьцаа эзэмшигч Х. Батхиг 12 хувийг эзэмшиж, Интергрупп Интернейшнл өөрийн хувьцаагаа зарж байгаа бол ноён Бруно Рашле хувьцааны эзэмшлээ 4 хувиар нэмсэн юм. Манай удирдлагын баг стратегийн шинэ түнш болон шинэ хэлцлийн эрлээ зогсоолгүй ажилласаар байна.


Бид Эрхэм Зорилгодоо дурдсанчлан, хөрөнгө оруулагчиддаа урт хугацааны үнэ цэнийг бий болгохыг эн тэргүүний зорилгоо болгон ажиллаж ирсэн билээ. 2016 онд ТУЗ болон удирдлагын багийн бүтээлч хамтын ажиллагааны үр дүнд компанийн ашиг 3.5 тэрбум төгрөгт хүрч, хувьцааны үнэлгээ 2,453.7 төгрөгт болсон байна. Үүнд хувьцаа эзэмшигч таны оруулсан хувь нэмрийг дурдахгүй байхын аргагүй - хэрэгтээ бол та бүгдийн бидэнд хүлээлгэсэн итгэл болон оруулсан мөнгөгүйгээр энэхүү тайланд дурдсан ажлын аль нь ч бүтэх боломжгүй байсан. Бидний гаргасан амжилт таны хүчинд бүтсэн гэсэн үг. Цаашдын тань ажил үйлсэд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе!

Жанчивын Оюунгэрэл
ТУЗ-ийн дарга


2016 он тоогоор

Өөрөөр заагаагүй бол сая төгрөгөөр	2015	2016	Өөрчлөлт
Нийт хөрөнгө	39,895.3	39,392.4	-1%
Зээлийн багц	1,824.6	5,360.5	194%
Үндсэн хөрөнгө	862.4	676.7	-22%
Эздийн өмч	34,006.1	37,466.0	10%
Нийт өр төлбөр	5,889.1	1,946.4	-67%
Цэвэр ашиг	-689.6	3,453.8	601%
Нийт орлого	11,831.4	12,455.4	5%
Нэгдлийн нийт хөрөнгө	35,567.1	39,201.5	10%
Нэгдлийн нийт ашиг	9,368,133	9,040,745	-3.5%
Эргэлтэнд буй нийт хувьцаа	13,486,359	14,151,451	5%
Нэгж хувьцааны өгөөж (төгрөг)	13.0	244.05	1,777%
Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)	2,176.0	2,453.7	13%


Цэвэр ашиг




Зээлийн багц



Нэгж хувьцаанд ногдох ашиг




Нэгж хувьцааны үнэлгээ



Харьцаа

	2015	2016	Өөрчлөлт
Зээлийн багц/Хөрөнгө	4.5%	13.6%	9.1%
Хөрөнгө оруулалт/Хөрөнгө	52.0%	64.9%	12.9%
Өр төлбөр/Хөрөнгө	14.7%	5.0%	-9.7%
Хөрөнгө оруулалт/Өөрийн Хөрөнгө	61%	68.2%	7.2%
Цалингийн Зардал/Хөрөнгө	0.6%	1.3%	0.7%
Үйл Ажиллагааны Зардал/Хөрөнгө	2.2%	3.0%	0.8%
Санхүүгийн Зардал/Хөрөнгө	0.2%	0.3%	0.1%
Гадаад Валютын Позици	-	-	-
ROE	-2%	9.21%	11.21%
ROA	-1.7%	8.76%	10.46%

Өөрийн хөрөнгийн өгөөж



Энэхүү ашиг нь компанийн балансын бүтцийн өөрчлөлт болон хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой гарсан. Бид 2015 онд өртөгт суурилсан тайланг хөрөнгийн үнэлгээн дээр суурилж гаргаж эхэлсэн.

2016 оны онцлох
үйл явдал





- ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн 4.26 хувийг худалдсаны төлбөр болох 6.2 сая доллар манай дансанд орж ирлээ. Тухайн үед 1 доллар 1,995 төгрөгтэй тэнцэж байв.
- Ард Санхүүгийн Нэгдэл Монгол Шуудан ХК-ийн хувьчлалд оролцон 17.38 хувийг нь 3.2 тэрбум төгрөгөөр худалдан авлаа.
- 2015 онд хийсэн хэлцлийн дагуу Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Секюритиз ҮЦК-ар дамжуулан өөрийн 2 том хувьцаа эзэмшигчээсээ 20.1 хувийн хувьцааг 5.4 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд 2016 оны 1 сард төлбөрийг нь гүйцэтгэв. Энэ дүнг оруулаад 2016 онд нийт 11 тэрбум төгрөгийн хувьцааг эргүүлэн худалдан авсан байна.
- Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнийг эхлүүлж, оны эцэст компани нь хаалттай хувьцаат компани болж чадсан юм. Жинст Увс ХК-тай нэгдэхтэй холбоотой бичиг баримтыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүллээ.
- Ард Менежмент компани хөрөнгө оруулалтын сангийн менежментийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авав.
- Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгалын жижиг хувьцаа эзэмшигчдээс компанийн 30 хувийг худалдан авч өөрийн эзэмшлээ 85 хувьд хүргэлээ. Тус компанийн 2 хувийг Хөрөнгө Оруулагч Үндэстэн эзэмшиж байна.
- Ард Холдингс Ард Кредит ББСБ-д 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн ба жижиг хувьцаа эзэмшигчээс 12.7 хувийг худалдан авч өөрийн эзэмшлээ 80.7 хувьд хүргэлээ.



- Ард Секюритиз УЦК-ийн тусламжтайгаар бид нийт 14.2 тэрбум төгрөгийн Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг арилжсан байна.
- Ард Секюритиз нь хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ болон брокер, дилер, андеррайтерын үйлчилгээний эрхээ хадгалан ажиллахад нь зориулан 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийв.
- Ард Санхүүгийн Нэгдэл Ард Актив дээр байсан тэтгэврийн үйлчилгээг тусгаарлан Ард Лайф буюу хуучнаар МТНД-д шилжүүллээ.
- Ард Санхүүгийн Нэгдэл нь нэмж Монгол Шуудан ХК-ийн 13.01 хувийг Хишиг Арвин Индастриал ХХК-ас хувьцаа болон бэлэн мөнгө оролцуулан худалдан авч, оны эцэст Монгол Шуудан ХК-ийн 31 хувийг эзэмшдэг боллоо. Энэхүү хэлцлийн дараа Х.Батхишиг нь 11.99 хувьтайгаар манай хамгийн том хувьцаа эзэмшигч болов.
- Ард Санхүүгийн Нэгдэл нь ТТДС-ийн 50 хувийг 9.8 тэрбум төгрөгөөр тооцож, удирдлагын багт нь худалдлаа. Уг хэлцлийг урт хугацааны эзэл, үл хөдлөх хөрөнгө болон хувьцаа солилцоогоор санхүүжүүлсэн юм.
- Бид Ард Секюритиз УЦК-ийн андеррайтинг хийсэн Хүннү Эйр компанийн 600,000 долларын бондыг амжилттайгаар босгон өглөө.
- Ноён Бруно Рашле нэмж 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийв.
- Оны эцэс гэхэд бид нийт хувьцаа эзэмшигчдийнхээ тоог 10 дахин өсгөж 3,000-д хүргэн Монгол Улсын 1,000 иргэн тутмын 1 нь Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигч болсон томоохон үйл явдал тохиолоо.



Гүйцэтгэлийн тойм

Бид 2016 оныг Хөрөнгө Оруулагч Үндэстэн гэх том хөдөлгөөнийг эхлүүлж, Монгол Шуудангийн хувьчлалд амжилттай оролцон урам зориг дүүрэн угтаж авсан билээ. Энэхүү үйл явдал нь бидний хувьд зөв алхам байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Жилийн туршид болсон бүхий л хэлцлүүдэд урам зориг, дэмжлэг үзүүлж байсан ТУЗ-ийн гишүүддээ талархал илэрхийлье.

2016 оныг эргэн харвал, эдийн засгийн амаргүй орчинд гялалзсан сайхан амжилтуудыг бид гаргажээ. Өнгөрсөн жилийн зарим онцлох үйл явдал, амжилтуудыг дор дурдлаа. Эдгээр нь бидний цаашдын бүтээн байгуулалтын үндэс болно хэмээн итгэж байна.

- Хөрөнгө Оруулагч Үндэстэн зөвхөн манай компанийн уриа байхаа больж 750 гаруй хувьцаа эзэмшигчидтэй хувьцаат компани, бүр цаашилбал бидний эхлүүлсэн нийгмийн хөдөлгөөн болж өргөжлөө. 2017 оны эхний хагаст Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компани болохоор эхэж байна. Ингэж чадвал Ард Санхүүгийн Нэгдэл нь түүнтэй нэгдэх замаар хөрөнгийн бирж дээр бүртгүүлэх боломж гарах юм. Үүний хажуугаар бид олон улсын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй болох арга замыг судалж байна.

- Монгол Шуудангийн хувьчлал олны анхаарлын төвд байж, 1991 оноос хойш явагдсан хамгийн үр нөлөө бүхий хувьчлал болсон гэж олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн юм. Ард Санхүүгийн Нэгдэл 9 сард өөрийн эзэмшиж буй хувиа нэмэгдүүлж, 30 хувьд хүргэсэн бол хувьцааны үнэ 185 төгрөгөөс жилийн эцэст 339.86 төгрөгт хүрлээ. Монгол Шуудан компанид засаглалын шинэчлэл хийгдэж, шинэ удирдлага ажилдаа шамдан орсноор 100 жилийн түүхтэй компанийн хөгжлийн шинэ түүхэн хуудас эргэлээ. Төр засгийн зүгээс үлдсэн 66 хувийг хувьчлах ажлыг эхлүүлсэн бол Монгол Шуудан компани нь шуудан хүргэлтийн үйл ажиллагаагаа шинэчлэн, санхүүгийн болон цахим худалдааны үйлчилгээ нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

- Ард Кредит компанийн хувьд зээлийн багцаа 38 хувиар өсгөж, 401.8 сая төгрөгийн ашигтай ажиллан кредит картыг анх удаа нэвтрүүллээ. Ард Холдингс өөрийн эзэмшлийн хувиа 58-аас 80.7 хувь болгож өсгөж чадлаа. Оны эцэст өөрийн хөрөнгө нь 3.3 тэрбум төгрөгт хүрсэн бол сүүлчийн хэлцлийн үнэ нь 1.8-ийн үржүүлбэртэй хийгдэв. Ард Кредит нь 2017 онд P2P буюу “хүнээс хүн рүү” гэх зээл олголтын үйлчилгээг нэвтрүүлж, мобайл мөнгөний үйлчилгээг судалж байна. Ард Кредитын ТУЗ-өөс ашгийнхаа 50 хувийг ногдол ашиг болгон хуваарилах шийдвэр гаргав.

- Ард Даатгал компанийн шинэ удирдлага компанид ужгирсан асуудлуудыг бүрэн шийдвэрлэж, компанийг эргүүлэн ашигт ажиллагаанд хүргэсэн юм. Ард Даатгал нийт 431.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, үнэлгээгээ нэмэгдүүлсэн бол бид бусад хувьцаа эзэмшигчдээс хувьцааг нь худалдан авснаар эзэмших хувиа 55-аас 83.03 хувь болгон өсгөлөө. Оны эцсийн байдлаар компанийн үнэлгээ 7.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа ба ногдол ашиг тараана гэсэн чиглэлтэй байгаа. Ард Даатгал нь үргэлжлүүлэн удирдлага, засаглалаа сайжруулж, цахим түгээлтийн суваг болон бусад шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

- Ард Секюритиз компани нь 153.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, Монголын хөрөнгийн зах зээл дээр манлайлах байр сууринд баттай очлоо. Мөн компани бие даасан судалгааны багийг ажиллуулан эрсдэлийн удирдлагыг улам эрчимжүүлэх тал дээр ажиллаж байна. Санхүүгийн боловсрол олгодог Ард Академийн цуврал сургалтууд маань тогворжиж ирлээ. Нэгдэл компаниас Ард Секюритизд 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн ба 2017 оны эхэнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл нь гарлаа.

- Тэтгэврийн бүтээгдэхүүнийг Монгол Улсад анхлан нэвтрүүлэгч Монголын Тэтгэврийн Нэгдсэн Данс буюу МТНД компани тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүнээ шинээр боловсруулан санал болгож эхэлсний хажуугаар тэтгэврийн системийн шинэчлэлийг хийх ажилд ханцуй шамлан орлоо. Бид тус компанийн нэрийг Ард Лайф болгож, ребрэндингийн ажлыг 2017 онд хийхээр төлөвлөж байна. Тус компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс Ард Санхүүгийн Нэгдэл 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр боллоо.

- ТэнГэр Системс компани нь бүтээгдэхүүний цэсээ бүрэн шинэчилж Ард Санхүүгийн Нэгдлийн охин компаниудыг үндсэн мэдээллийн програм хангамжаар хангаж байна. Бид Уайлд Дижитал Эйженсийг худалдсаны дараа дижитал маркетинг, брэнд вэб сайт хийх ажлуудыг ТэнГэр Системсд бүрэн шилжүүлсэн юм. Тус компани нь хадгаламж зээлийн хоршоодын хэрэглэгдэг програмыг шинэчлэн хөгжүүлж, харилцагч хоршоод болон банк бус санхүүгийн компаниудад нэвтрүүлж байна. Ард Дижитал Базаар буюу Хөрөнгө Оруулагч Үндэстний цахим зах зээлийг босгоход голлох үүрэг гүйцэтгэнэ гэж үзвэл тус компанид шинэ хүний нөөц болон хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай байгаа.

- Ард Менежмент компани 2016 онд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авсан бөгөөд 2017 онд эдийн засаг сэргэхтэй зэргэцэн Ард Менежментийн анхны томоохон ажлуудыг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна. Мөн тус компани нь даатгалын сан, тэтгэврийн сан болон Ард Санхүүгийн Нэгдлийн үл хөдлөх хөрөнгийг удирдах чиглэлийг барьж байна.

- Бид 10 жил хамтран ажилласан ТТДС-ийн өөрийн эзэмшлийн 50 хувийг 9.8 тэрбум төгрөгөөр тооцож удирдлагын багт нь бүрэн шилжүүлж өглөө. Манай компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ганбат, хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүдээр ажиллаж ирсэн Нэмэхбаатар, Сэргэлэн, Уянга нартаа цаашдынх нь ажилд амжилт хүсье.

- 2016 оны хамгийн сүүлийн өдөр Ард Санхүүгийн Нэгдэл нь 600,000 долларын бондыг Хүннү Эйр компанид амжилттайгаар босгож өгөв. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон үр нөлөө үзүүлсэн үйл явдал болсон юм.

Компанийн засаглалын хувьд томоохон өөрчлөн шинэчлэлт хийгдэж ирлээ. ТУЗ хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалах төлөвлөгөөг баталсан бол бид шинээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Дотоод аудитор, Хууль эрх зүйн нийцэлт хариуцсан захирал авч, харин Санхүү болон Хөрөнгө оруулалт хариуцсан захирлуудыг дотоодоосоо охин компанийн захирлуудаар давхар хашуулж байна. Бид одоо ч гэсэн Эрсдэл хариуцсан захирлыг хайж байгаа. Манай баг компанийн тайлагналын хэм хэмжээ болон ил тод байдлыг сайжруулахын төлөө үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү тайланг гаргахад бидний оруулсан хувь нэмэр, хүчин чармайлтыг үнэлнэ гэж найдаж байна.

Эдийн засгийн хүнд орчинд Ард Санхүүгийн Нэгдлийн нийт хөрөнгө 394 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ хугацаанд бид өөрийн 10.8 гаруй тэрбум төгрөгийн хувьцааг эргүүлэн худалдан авсныг тооцвол амжилттай ажиллалаа гэж дүгнэж болох юм. Манай зээлийн багц 1.8-аас 54 тэрбум төгрөгт хүрч, хөрөнгө оруулалтын багц маань 20.8-аас 25.5 тэрбум болж өслөө. Мөн борлуулахад бэлэн 3 тэрбум төгрөгний үндсэн хөрөнгө бий болсноос гадна бидний өөрийн хөрөнгө 37.4 тэрбум төгрөг болж өссөн байна.

Бид хөрөнгө оруулалт, зээлийн хүүгийн орлого болон гадаад валютын ханшийн удирдлагад томоохон ахиц гаргаж чадсан. Ард Санхүүгийн Нэгдлийн нийт зардал 1.8 тэрбум төгрөг байсан ба үүнээс 525 сая төгрөгийг цалин хөлс, 116 сая төгрөгийг хүүгийн өглөгт төлсөн бол 356 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн гүйлгээтэй холбоотой нэг удаагийн хасалт байдлаар бүртгэлээ.

Ард Санхүүгийн Нэгдэл нь ребрэндинг болон маркетингийн ажлаа улам эрчимжүүлж ажиллалаа. Миний бодлоор, Ардын брэнд нь санхүүгийн салбартаа хамгийн түгээмэл, олны итгэлийг хүлээсэн брэндийн нэг болж чадсан.

Эдийн засгийн хүндрэлтэй үед манай хувьцааны арилжаа маш сайн байлаа. Монголын Хөрөнгийн Бирж дээр 2016 оны турш нийт 49 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсантай харьцуулахад манай компани дангаараа 14.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь үүнийг нотолж байгаа юм.

Ард Санхүүгийн Нэгдлийн дотоод үнэлгээ 34 тэрбум төгрөг болж, нэгж хувьцааны үнэлгээ 2453.8 төгрөгт тус тус хүрлээ. Бид 2017 онд хөрөнгийн бирж дээр гарахаасаа өмнө Ард Кредит ББСБ-ын үйл ажиллагааг өргөжүүлэхээр бонд босгох боллоо. Ард Лайф болон Ард Менежмент нь үйл ажиллагаагаа идэвхжүүлж, Нэгдэл компани нь Монгол Шуудангийн хувьчлалд оролцож, түүний хажуугаар Ард Кредитын хөрөнгийг тогтмол нэмж Ард Банк болгох зорилгоор бэлэн мөнгөө нөөж бэлдэнэ.

Ард Санхүүгийн Нэгдэл нь цаашид дижитал хувьсгалыг Монголдоо эхлүүлэх санаачлагын манлайд ажиллах зорилготойгоор том өөрчлөлтийн өмнө ирээд байна. 2017 онд бид "Хил Хязгааргүй Банкирууд" гэсэн уриан дор ажиллах болно. Мөнх Хөх Тэнгэр биднийг ивээг.

**Хутагт Ч. Ганхуяг,
Гүйцэтгэх захирал**

Компанийн түүх



Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Коор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгодоо нэгдэн өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-GE ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-GE ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2005 оны 9 дүгээр сард ХасБанкны үүсгэн байгуулагч гүйцэтгэх удирдлагын санаачлагаар “Employ-ee Investment Trust” буюу ИАЙТи ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

ИАЙТи нь 2005 онд үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн өмч бүхий дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 800 гаруй хувьцаа эзэмшигчтэй, 40 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.

2013 онд манай гол хувь нийлүүлэгчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм. Энэхүү стратегийнхаа хүрээнд Ард Кредит ББСБ, Ард Даатгал ХХК, Ард Секюритиз ҮЦК ХХК болон Ард Актив ХЗХ-д тасралтгүй хөрөнгө оруулсаар байгаа билээ. Ард Менежмент ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх эрхээ авч чадсан байна. Ард Лайф ХХК нь 2017 оноос эхлэн тэтгэврийн сангийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж байна. 2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч нь болж чадсан билээ.

Бид бүтээсэн баялгийнхаа эзэн болох ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-йг нээлттэй арилжааллахаар хичээн ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан бид 2015 оны сүүлээр хэлбэрээ өөрчлөн хаалттай хувьцаат компани болж бүртгүүлж чадсан. Бид 2017 ондоо нээлттэй арилжаалагдахаар зорин ажиллах ба цаашлаад банкны лиценз авахын төлөө явах болно.

Эрхэм зорилго: Ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэржүүлэн барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд түвшинд барих бодлогыг мөрдөнө.

Алсын хараа: Бид хувьцаа эзэмшигчид болох ард иргэдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг дээдэлсэн Үндэсний хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани болно.

Мөрдөх зарчим болон
Давуу шинж чанар



Мөрдөх зарчим

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;

Ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоон дагаж, Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох журам зааврыг чандлан мөрдөнө;

Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана;

Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана;

Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрхэмлэнэ;

Зах зээлд шинийг нэвтрүүлж, тэргүүлэх бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд мөрдөж ажиллана;

Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд чандлан мөрдөнө;

Хамгийн хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлагыг чанд мөрдөнө.



Давуу шинж чанар:

Үндэсний хөрөнгө оруулалттай санхүүгийн цогц үйлчилгээ бүхий нэгдэл;

Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал, тэргүүний менежмент;

Санхүүгийн салбарт шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч хамт олон;


Технологийн дэвшил, зах зээлийн мэдрэмж, туршлага хуримтлуулсан маркетингийн баг;

Нэр хүнд бүхий компани, хувь хүмүүсийн сэтгэл шингэсэн хөрөнгө оруулалт;

Өрсөлдөх чадвар, үр ашгийг цогцлуулсан түншлэл;

Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж;

Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага.



Эдийн засгийн байдал,
Санхүүгийн салбар, үзүүлэлт



Эдийн засаг

2011 онд Монгол Улс 17.4 хувь буюу дэлхийн хамгийн өндөр эдийн засгийн бодит өсөлттэй гарч байв. Гэвч энэхүү хоёр оронтой өсөлтийг хадгалж чадаагүй бөгөөд эдийн засгийн өсөлт тогтмол буурсаар ирсэн юм. 2016 онд Монгол Улсын ДНБ-ийн өсөлт 1 хувьд хүрэв. Энэ нь Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон Олон Улсын Валютын Сан зэрэг байгууллагуудаас таамагласан өсөлтөөс өндөр байгаа хэдий ч сүүлийн 7 жилийн өсөлттэй харьцуулахад хамгийн доод түвшинд хүрэв. Эдийн засагчид эдийн засгийн хүнд, бэрхшээлтэй үед өсөлттэй байх нь эерэг гэж тодотгодог ба энэхүү 1 хувийн өсөлтийг хувийн хэвшлийн оролцоо хангасан юм. Хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлсэн ба Рио Тинтогоос хэрэгжүүлж буй Оюу Толгойн зэс болон алтны төсөл, оны 2 дугаар хагаст Хятадын нүүрсний эрэлт нэмэгдсэнээс үүдсэн үнийн өсөлт зэргээс шалтгаалсан уул уурхайн салбарын төслүүдийн эрчимжилт ДНБ-нд нөлөөллөө.


2016 онд нэрлэсэн ДНБ 23.9 их наяд төгрөгт хүрсэн ба 2010 оны суурь үнээр тооцвол 16 их наяд төгрөг болсон байна. Мөн төсвийн алдагдал ДНБ-ий 15 хувьтай тэнцэж, 3,667.8 тэрбум төгрөгт хүрчээ. 2016 онд урсгал данс 449 сая долларын алдагдалтай, хөрөнгийн данс 92 сая долларын илүүдэлтэй,

санхүүгийн данс 615 сая долларын алдагдалтай гарч, 277 сая долларын дансны тохируулга хийснээр нийт төлбөрийн тэнцэл 18 сая долларын алдагдалтай гарсан байна.

2011 оноос 2016 онуудад гадаад өр төлбөрийн хэмжээ 152 хувиар өсч 24.3 тэрбум долларт хүрсэн бөгөөд гадаад валютын нөөц 1.3 сая долларт хүрч, 115 хувиар буюу 1.5 сая доллароор буурсан байна. Мөн энэхүү хугацаанд төгрөгийн доллартай харьцах ханш 76 хувиар унаж 1 доллар 2482.6 төгрөгтэй тэнцлээ. 2016 онд Монголбанк 1.2 тэрбум долларын интервенц хийсэн боловч, төгрөгийн ханш 24 хувиар унасан байна. 2016 оны 12 сарын байдлаар Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 578.3 тэрбум төгрөг байна. Инфляцийн түвшин улсын хэмжээнд 1.1 хувьтай гарсан бөгөөд Улаанбаатар хотын хувьд 0.5 хувьтай байна.

2016 онд нийт гадаад худалдааны эргэлт 8,275.3 сая долларт хүрснээс экспорт 4,917.3 сая доллар, импорт 3,357.9 сая долларыг эзэлж, гадаад худалдааны тэнцэл 1,559.4 сая долларын ашигтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 687.6 сая доллараар нэмэгдсэн байна.


ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр (сая төгрөг)




Гадаад худалдаа (сая доллар)




Улсын төсвийн
тэнцвэржүүлсэн орлого,
зарлага, тэнцэл, жилээр
(сая төгрөг)



Гадаад валютын улсын
нөөц
(сая доллар)



Нийт гадаад өр
(сая доллар)



Санхүүгийн салбар


Монголбанкны гаргасан тайланд мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны 12 сарын эцэст 12.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буюу 1,927.0 тэрбум төгрөгөөр өсчээ. Энэхүү өсөлт бий болоход төгрөгийн хадгаламж 172.3 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 133 тэрбум төгрөг, валютын хадгаламж 107.8 тэрбум төгрөг болон хадгаламжийн байгууллагаас гадуурхи мөнгө 32 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөллөө. Харин валютын харилцах 83.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Мөн гүйлгээнд гарсан бэлэн мөнгө жилийн туршид 16.6 хувиар буюу 117.0 тэрбум төгрөгөөр өсч 823.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны эцэст 124 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буюу 716.1 тэрбум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.9 хувь буюу 58.8 тэрбум


төгрөгөөр нэмэгдэж, 912.8 тэрбум төгрөгт хүрснээр нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.3 хувийг эзэлж байна. Харин чанаргүй зээлийн хувьд өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 213 тэрбум төгрөгөөр өсч, оны эцэст 1,082.8 тэрбум төгрөгт хүрснээр нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 хувийг эзэлж байна.

2016 онд үнэт цаасны зах зээл дээр 462.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулбал 48.5 хувиар буюу 435.6 тэрбум төгрөгөөр буурчээ. Мөн 97.1 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оноос 2.3 дахин буюу 554 сая ширхгээр өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2016 оны эцэст 11,605.7 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 6.16 хувиар буюу 673.3 нэгжээр буурчээ.


Зээлийн хүү, хувиар




Зээлийн өрийн үлдэгдэл, сар бүрийн эцсийн байдлаар (тэрбум төгрөг)



Үнэт цаасны зах зээлийн
үнэлгээ, сараар
(сая төгрөг)



Даатгалын салбарын
актив
(сая төгрөг)



Үнэлгээ



	2014	2015	2016	Эзэмшлийн хувь	Үнэлгээ	Тайлбар
Урт хугацааны хөрөнгө оруулалт						
Тэнгэр Санхүүгийн Нэгдэл	11,685	-	-	-		Зарсан
Монгол Шуудан	-	-	9,681	28.5%	Зах зээлийн үнэ	Өсөлттэй
ТТДС	9,825	9,825	-	-	Хөрөнгийн үнэлгээ	Зарсан
Ард Даатгал	6,637	6,337	7,688	83.03%	Өртөг	Өсөлттэй
Ард Кредит	1,600	1,853	3,818	80.70%	Мөнгөн урсгал	Өсөлттэй
Ард Секюритиз	983	983	2,126	100.00%	Мөнгөн урсгал	Өсөлттэй
Номын Хишиг	1,382	1,382	1,780	20.00%	Хөрөнгийн үнэлгээ	Өсөлттэй
Бусад	219	464	824			
Зээл, ХОЗҮХХ	959	3,326	8,362			
Нийт	33,290	24,171	34,279			
Биет болон биет бус хөрөнгө	897	862.5	726			
Бэлэн мөнгө	408	1,328	166			
Цэвэр авлага	-596	2,229	-1,163			
Хөрөнгийн олз			716			
Нийт үнэлгээ	34,000	29,351	34,724			

27.55 хувийг эзэмшиж байгаа боловч манай шууд хөрөнгө оруулалттай Алтан Хоромсог ҮЦК-д 1.05 хувь байршсаныг үнэлгээнд оруулж харуулав.

Охин компанидаа өөрийн хувьцааг авах зорилгоор олгосон зээлийг оруулаагүй бөгөөд арилжааны зорилгоор авсан үл хөдлөх хөрөнгийг оруулав.

Үл хөдлөх хөрөнгийн наймаан дээр гарсан олзыг харуулав.



2016 онд Ард Холдингс нь хэд хэдэн том хэлэлцээрийг амжилттай хийсэн юм. Бид Монгол Шуудан хувьцаат компанийн хувьчлалд амжилттай оролцон олон нийтэд гаргасан 34 хувийн хувьцааны 30.6 хувийг нийт группын хэмжээнд (дангаараа 27.55 хувийг) эзэмшиж байна. Энэ хувьцааг бид анх авахад 185 төгрөг байсан бол оны эцэст 339.86 төгрөгөөр хаагдаж, бид 2.58 тэрбум төгрөгийн ашгийг бүртгээд байна.

Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгал болон Ард Кредит дэх хувиа нэмж, хөрөнгө оруулалтаасаа -7.8 болон 33.9 хувийн өгөөжийг тус тус хүртсэн юм. Хэд хэдэн улирал дараалан алдагдалтай ажилласан Ард Даатгал 2016 оны III улиралд ашигтай ажиллаж эхэлсэн ба цаашид тус компанийн үнэлгээнд өсөлт гарна гэж бид таамаглаж байна. Мөн Ард Кредитын үнэлгээ цаашид ч өсөх төлөвтэй байгаа бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл бага өртөгтэй санхүүжилт татаж өгснөөр тус компанийн зах зээл дэх байр суурийг баталгаажуулж, хөгжлийг нь хурдасгах болно.

Ард Секюритиз менежментийн шинэчлэл хийснээр цэвэр ашгаа нэмэгдүүлж, шинэ удирдлагын баг үйл ажиллагаагаа тогтвортойгоор өргөжүүлж эхэллээ. Ард Секюритизийн үнэлгээг мөнгөн урсгалын аргаар тооцсон тул өмнөх үеийн хэрэгжсэн алдагдлууд нь үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн болно.


Ард Санхүүгийн Нэгдэл нь бэлэн мөнгө, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа солилцоо болон зээлээр ТТДС дахь хувиа зарсан юм. Ард Санхүүгийн Нэгдэл өөрийн үл хөдлөх хөрөнгийг арилжсанаар 716 сая төгрөгийн хэрэгжээгүй ашиг үүсч үнэлгээнд тусгагдсан байна.



Компанийн бүтэц



Хувьцаа эзэмшигчийн бүтэц



	2014		2015		2016	
15 хувьцаа эзэмшигчийн дүн	12,628,484	82%	10,339,607	77%	11,592,956	82%
Бусад хувьцаа эзэмшигчид	2,862,806	18%	3,146,752	23%	2,558,495	18%
Нийт саналын эрхтэй хувьцаа	15,491,290	100%	13,486,359	100%	14,151,451	100%
Саналын эрхгүй хувьцаа (АС, АМ, АЛ)	1,703,074		3,708,005		3,042,913	
Нийт гаргасан хувьцаа	17,194,364		17,194,364		17,194,364	

Компанийн бүтэц, бүрэлдэхүүн

Удирдлагын бүтэц

Хутагт Ч. Ганхуяг	Гүйцэтгэх захирал
Ариунагийн Идэрбат	Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал, Ард Секюритиз УЦК-ийн Гүйцэтгэх захирал
Чулууны Ганзориг	Санхүү эрхэлсэн захирал, Ард Кредит ББСБ-ын Гүйцэтгэх захирал
Соронзонболдын Халиунаа	Хууль, эрх зүйн нийцэлт эрхэлсэн захирал
Жаргалангийн Алтангүний	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
Мөнхбатын Мөнх-Эрдэнэ	Дотоод аудитор
Билэгтийн Тамир	Маркетинг эрхэлсэн захирал, Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал
Жаргалсайханы Золзаяа	ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга

Хороод

Хөрөнгө Оруулалт, Санхүү, Эрсдлийн хороо	Засаглал, Цалин урамшуулал, Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо
П. Батбаяр (Хорооны дарга)	Ц. Ариунтөгс (Хорооны дарга)	
В. Баяржаргал	Л. Соронзонболд	
Г. Цогбадрах	Х. Антони	
Х. Антони		
Ч. Ганхуяг		
		Р. Бруно (Хорооны дарга)
		П. Батбаяр
		О. Одбаяр
		Х.Батхишиг



ТУЗ-ийн бүтэц

Жанчивын Оюунгэрэл

Луна энд Луна ХХК
Гүйцэтгэх захирал
1,450,801

Хутагт Ч.Ганхуяг

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Гүйцэтгэх захирал
1,132,000

Хишигдоржийн Батхишиг

Хишиг Арвин Индастриал ХХК
Гүйцэтгэх захирал
1,689,415

Бруно Рашле

АДВЕК Нэгдэл АГ ТУЗ-ийн дарга
1,302,016

Антони Хоброу

ВенчурсУан Гүйцэтгэх захирал
1,304,043

Одончимэдийн Одбаяр

Мон Интернэйшнл
Гүйцэтгэх захирал
452,000

Лхагвасүрэнгийн Соронзонболд

ХХБ Орлогч захирал, Хараат бус гишүүн
306,710

Цогбадрахын Ариунтөгс

Монголын Алт (МАК) ХХК Хөрөнгө оруулалт,
эрсдэлийн удирдлагын газрын захирал
873,000

Пүрэвжаргалын Батбаяр

Резилиенс Майнинг ТУЗ-ийн гишүүн
11,000

Галбадрахын Цогбадрах

Хараат бус гишүүн
74,890

Ванданцэрэнгийн Баяржаргал

Интергрупп Интернэйшнл ХХК
Гүйцэтгэх захирал
917,333





Үйл ажиллагааны тайлан болон
удирдлагын шинжилгээ



Ард Санхүүгийн Нэгдэл нь санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэгч тэргүүний байгууллага болохын төлөө ажиллаж ирсэн билээ. Бид байгууллагын хөгжлийн бүхий л хэмжүүрээр томоохон ахиц, дэвшлийг гаргасаар байна. Байгууллагын хувьд, багийн хувьд бид илүү чамбайрч, илүү хүчирхэгжиж ирлээ.

2015 оны сүүлээр бид манай хоёр том хувьцаа эзэмшигч болох ЮБиАйЖи болон Аполло Венчурсаас 54 тэрбум төгрөгөөр хувьцаагаа эргүүлэн худалдан авсан юм. Уг хоёр хувьцаа эзэмшигч нь бидний гаргасан хувьцааны 20 гаруй хувийг эзэмшиж байв. Бид тус арилжааг хийхдээ Ард Секюритиз УЦК-д зээл олгох байдлаар хийсэн ба ингэснээр бид тэрхүү хувьцааг эргүүлэн борлуулах боломжтой болсон юм. Энэхүү наймааны санхүүжилт нь ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн үлдсэн 4.2 хувийг зарснаас орж ирсэн билээ.

2016 оны туршид Ард Санхүүгийн Нэгдэл нь нийт 54 тэрбум төгрөгийн хувьцааг хэд хэдэн удаагийн хэлцлээр эргүүлэн худалдан авсан бол 6.3 тэрбум төгрөгийн хувьцааг худалдаж эргэлтэнд оруулсан ба манай хувьцаа эзэмшигчид 2.5 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний хувьцааг жилийн туршид хоорондоо арилжаалжээ. Монголын Хөрөнгийн Бирж дээрх I ангилалын компаниудын бүтэн жилийн турш хийгдсэн арилжаа нь нийт 23.7 тэрбум төгрөг байсан нь манай хувьцааны арилжааны идэвх ямар байгааг бэлхнээ илтгэж, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа нь хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдвал ямар их боломж гарахыг харж болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн гол шийдвэр гаргах байгууллага гэдэг статусаа илүү баталгаажуулж ажиллалаа. 2017 онд бид анх удаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргын орон тоог бий болгож ажиллуулав. ТУЗ-ийн хурлын үйл явц илүү сайжран шийдвэрүүд цаг алдалгүй гарч байсан бөгөөд байнгын хороод ажил үүргээ сайн гүйцэтгэлээ.

Манай ТУЗ АйПиОу хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, Хууль Эрх Зүйн Нийцэлт Хариуцсан Захирал болон Эрсдэл Эрхэлсэн Захирлын орон тоог баталж шууд ТУЗ-д тайлагнадаг болгов. Ард Кредитын Гүйцэтгэх Захирал Санхүү Эрхэлсэн Захирлаар, Ард Секюритизийн Гүйцэтгэх Захирал Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн Захирлаар тус тус томилогдлоо.

Нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмууд шинэчлэгдэн батлагдав. Ард Холдингсын тайлагнал улам бүр сайжирч ирсэн бөгөөд бид аудиторуудын санал дүгнэлтийг бүрэн хэрэгжүүлж

ажиллалаа. Ард Санхүүгийн Нэгдэл 2017 онд байгууллагын нөөцийн удирдлагын ИАрПи, харилцагчийн үйлчилгээний СиАрЭм системүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал ЖАлтангүний нь 2016 онд амаржсаны чөлөө авсан бөгөөд бид түүний оронд хүн ажиллуулахгүйгээр зохицуулав. Мөн ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ нь оны хагасаас эхлэн амаржсаны чөлөө авсан тул түүнийг Ард Даатгалын Ерөнхий нягтлан бодогч Т.Батцэнгэл орлон ажиллаж Ард Санхүүгийн Нэгдлийн ажлыг тасалдуулалгүй явууллаа.

Бид 524.9 сая төгрөгийг цалин урамшуулал, хувьцаа хуваарилалт зэрэг хүний нөөцийн зардалд зарцуулжээ. Акела Секюритиз компани манай хамгаалалтын үйлчилгээг бүрэн хариуцан хийж байна.

2016 онд Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнийг өрнүүлсэнтэй холбоотой олон нийтийн суртгалчилгаанд бид онц ач холбогдол өгч ажиллалаа. Бид 288.9 сая төгрөгийг ПиАр болон суртгалчилгаанд зарцуулсан бөгөөд үр дүнд нь Ард Санхүүгийн Нэгдэл болон манай салбар компаниуд асар хурдтайгаар Монгол Улсад өргөнөөр танигдаж, хүлээн зөвшөөрөгдлөө. Бид түрээсийн төлбөрөө багасгасан хэдий ч төгрөгийн ханшны уналтаас үүдэн түрээсийн зардал хэвэндээ гарсан байна. Манай түрээсийн гэрээний төлбөр доллараар төлөхөөр заасан байгаа бөгөөд 2016 онд төгрөгийн ханш 25 хувиар унасан ч бид энэхүү алдагдалыг 80 хувийн хувьцаа эзэмшдэг хүнд өгсөн зээлээр тэнцүүлэн хааж чадлаа.

Бид тал талаас нь эргэцүүлэн бодож, хэлэлцсэний дараагаар Ард Санхүүгийн Нэгдлийн бүх охин компаниуд нэг байршлаас үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж шийдсэн юм. Ард Кредит болон Ард Даатгалын удирлагууд нэгдлийн бусад компаниудтай харилцан ажиллахад дөхөмтэй байх зорилгоор Номын Хишигт байрлах Ард Санхүүгийн Нэгдлийн байранд нүүж ирснээр манай удирдлагын баг өөр хоорондоо уялдаа холбоотой ажиллах боломжтой боллоо. Энэ нь эдийн засгийн тогтворгүй байдал болон нэгдэл компаниудын хурдтай өсөлтийн үед хамгийн тохиромжтой шийдэл болсон гэж үзэж болно. Ард Даатгал шинэ оффисын байр худалдан авсан тул түүнийгээ түрээслэх эсвэл зарах шийдэлд хүрсэн байна. Бид энэ оффисын байрыг группын эзэмшдэг бусад үл хөдлөх хөрөнгийн хамтаар Ард Менежментийн хариуцдаг тусгай санд оруулах нь зөв гэж үзэж байгаа.

3 сард ТУЗ 1 тэрбум төгрөгийн банкны шугамын зээл авахыг зөвшөөрсөн бөгөөд энэ мөнгийг хэд хэдэн арилжааг санхүүжүүлэх болон богино хугацааны бэлэн мөнгөний хомсдлын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна. Уг зээлийг ТУЗ-ийн баталсан анхны хаалттай бондын санхүүжилтээс 2017 оны 1 дүгээр улиралд багтаж эргүүлэн төлсөн болно.

Удирдлагын баг ТУЗ-тэй хамтран компанийн тайлагналын ил тод байдлыг сайжруулах тал дээр шаргуу ажиллаж, тасралтгүй сайжруулсаар байна. Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн ил тод байдлаараа Монгол Улсад тэргүүлж байгаа гэдгийг бахархалтайгаар хэлмээр байна. Бид зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төдийгүй сошиал медиагаар дамжуулан бичлэг, подкаст болон цахим тайланг хувьцаа эзэмшигчиддээ хүргэдэг анхны компани болсон юм. Түүнчлэн 2016 оны урьдчилсан тайланг анх удаагаа шуудангаар түгээсэн билээ.

Бид компани хоорондын өглөг авлагыг цэгцлэн тооцоо нийлсэн болно. Гишүүн компаниуд болон өөрийн ажиллагсдын богино хугацааны авлагыг Ард Кредитын зээлийн багц руу шилжүүлэв. Ард Секюритиз болон бусад охин компанийн зээл нь Ард Санхүүгийн Нэгдэлд эзэмшдэг хувьцааг авах зорилгоор олгогдсон юм. Хуулийн дагуу компани өөрийнхөө халаасны хувьцааг чөлөөтэй арилжих боломжгүй учраас бид ийм шийдэлд хүрсэн болно. Энэхүү хувьцаа нь Ард Секюритиз болон бусад охин компаниудын нэр дээр байх боловч манай компанийн компанийн үнэлгээнээс хасагдаж, харин арилжих эрхээ бид хадгалж үлдэж байгаа юм.


Манай компанийн 20 хувийг нь эзэмшдэг Өнгөт хэвлэл ХХК-ийн 80 хувийг эзэмшигчид зээлдүүлсэн 750 мянган долларын зээл нь манай багцын хамгийн том зээл байна. Энэхүү зээлийг 2015 онд олгосон бөгөөд үл хөдлөх хөрөнгө болон газрыг нь барьцаанд авсан байгаа. Гэрээний дагуу зээлийн хүүг манай төлөх түрээсийн нийт 266.5 сая төгрөгөөс хасах байдлаар хангаж явж байна.

Манай удирдлага 2016 онд бүх гол компаниудад эзэмших хувиа нэмэгдүүлж чадсан байна. 2016 онд Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал сайнгүй, УИХ-ын сонгуультай жил байсан хэдий ч бид хөрөнгө оруулалтын багцаа нэмэгдүүлж чадсандаа баяртай байгаа. 12 сард Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс өөрийн хөрөнгийн доод хэмжээний шаардлагыг хангах үүднээс Ард Кредитэд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан бөгөөд жижиг хувь эзэмшигчээс 570 сая төгрөгийн хувьцааг нэмж авснаар манай эзэмших хувь 80.7 болж өслөө. Бид энэ хэлцэлд Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох зөвшөөрлийг авахаар материалаа хүргүүлсэн байгаа. Ард Даатгалд нэмэлт 30 хувийг авахын тулд дотоодоосоо 2 тэрбум төгрөгийг дайчилж гаргалаа. Энэхүү наймаанд үл хөдлөх хөрөнгө болон хувьцаагаа оролцуулан зарим хэсгийг цувуулж төлөх нөхцөлтэйгээр хийсэн бөгөөд энэхүү олон хэсгээс бүрдсэн ярвигтай цогц арилжааг бид амжилттайгаар гүйцэтгэж чадсан юм. Ингэснээр бид Ард Даатгалын 85 хувийг эзэмшиж эхэллээ (үүнээс Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2 хувийг эзэмшдэг). Бид Монгол Шуудангийн 13 хувийг 1.2 тэрбум төгрөг болон компанийн 11.99 хувийн хувьцаагаар нэмж худалдан авч чадсан юм. Ард Холдингс одоо Монгол Шуудангийн нийт хувьцааны 31 орчим хувийг эзэмшиж байгаа бөгөөд үлдсэн 3 хувь нь Монголын Хөрөнгийн Бирж дээр эргэлдэж, үлдсэн 66 хувь нь Засгийн Газрын өмч хэвээр байна. Мөн Ард Секюритиз ҮЦК-д 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийн 2017 оны 1 дүгээр улиралд санхүүгийн зохицуулагчаас зөвшөөрлөө авч чадлаа.

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2016 онд 3.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Монгол Шуудан, Ард Кредит болон Ард Даатгал компаниуд маань амжилттай ажилласан учраас бид ногдол ашиг авах боломжтой болоод байна. Бид ирэх жилүүдэд ногдол ашиг хуваарилах боломжтой хөрөнгө оруулалтынхаа тоог нэмэгдүүлэхээр чармайн ажиллах болно.



Томоохон хэлцэл



ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн үлдэгдэл хувиа зарав

Ард Холдингс нь өөрийн эзэмшлийн нийт 705,596 ширхэг ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцаагаа нэг бүрийг нь 8.77 доллараар үнэлж Японы ОРИКС (210,798), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (210,798) болон Монголын Хөрөнгө Оруулалтын Сан (285,000)-д нийт 6,196,847 долларын үнээр 2015 онд зарсан юм. Төлбөр хүлээн авах үед буюу 2016 оны 1 сард долларын ханш 1,995 төгрөг байсан бөгөөд бид нийтдээ 12,362,709,605 төгрөг хүлээн авав.

Үүнээс 5.4 тэрбум төгрөгийг ЮБиАЙЖи болон Аполло Венчурсын Ард Санхүүгийн Нэгдэлд эзэмших 20.9 хувийн хувьцааг Ард Секюритизээр дамжуулан худалдан авахад, 3.3 тэрбум төгрөгийг Монгол Шуудангийн 17.4 хувийг авахад тус тус зарцуулсан байна. Үлдэгдэл 2.3 тэрбум төгрөгөөр богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 1.2 тэрбумаар бусад зээл, өр төлбөрөө барагдуулсан болно.

Ард Даатгалд эзэмших хувьцаагаа нэмэв

2016 оны 5 сард Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгалын 27.72 хувийг 1.9 тэрбум төгрөгөөр нэмж эзэмшихээр тохиролцоо хийв. Үүнд Блю Планет ХХК-ийн эзэмшиж байсан 16.72 хувийг үл хөдлөх хөрөнгө болон 1.2 тэрбум төгрөгөөр худалдан авсан бол 11 хувийг хувьцаа эзэмшигч ДЧулуунцэцэгээс Ард Санхүүгийн Нэгдлийн 157,903 ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг 2,426

төгрөгөөр тооцон өгөхөөс гадна бэлнээр 383.1 сая төгрөг төлөх хэлцэл хийн авлаа. Энэхүү хоёр арилжааны дүнд Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил 83.03 хувь болсон бөгөөд бид Ард Даатгалын үйл ажиллагааг дангаараа удирдан чиглүүлэх боломжтой болсон юм.

Монгол Шуудангийн хувьчлал

Ард Санхүүгийн Нэгдэл 2016 оны 1 сард болсон Монгол Шуудангийн хувьчлалд амжилттай оролцож олон нийтэд санал болгосон компанийн нийт хувьцааны 34 хувийг авах сонирхлоо илэрхийлсэн бөгөөд нийт компанийн 17.38 хувийг авч чадсан бол үлдсэн 16.62 хувь нь бусад хөрөнгө оруулагчдад очсон юм.

2016 оны 3 дугаар улиралд манай компани Монгол Шуудангийн хувьцаа эзэмшигч иргэн Х.Батхишигтэй хувьцаа солилцох

хэлцэл хийж 13.01 хувийг нэмж авсан билээ. Уг хэлцэлд нийт 1.2 тэрбум төгрөгийн бэлэн мөнгөнөөс гадна Ард Санхүүгийн Нэгдлийн нийт 1,689,415 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,750 төгрөгөөр үнэлэн өгсөн бөгөөд үр дүнд нь иргэн Х.Батхишиг нь Ард Санхүүгийн Нэгдлийн хамгийн том хувьцаа эзэмшигч болсон юм.

ТТДС-иас гарав

2016 оны сүүлээр бид Техник Технологийн Дээд Сургуульд эзэмшдэг 50 хувиа тус сургуулийн удирдлага болон хувьцаа эзэмшигчдэд нийт 9.8 тэрбум төгрөгөөр үнэлэн худалдав. Энэхүү хэлцэлд нийт 3 тэрбум төгрөгтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгө, 3.6 тэрбум төгрөгтэй тэнцэх Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа, 3.2

тэрбум төгрөгийн зээлийг солилцон авлаа. 2008 онд манай компани ТТДС-ийн 50 хувийг нийт 1.9 тэрбум төгрөгөөр үнэлэн авч байсан бөгөөд 8 жилийн дараа 411 хувийн ашиг хийж хөрөнгө оруулалтаа татлаа.

Ард Кредитын 80.7 хувийг эзэмших боллоо

Ард Кредит нь бидний хувьд стратегийн ач холбогдолтой компани бөгөөд 2016 онд бид өөрийн эзэмшлийн хувиа 58 хувиас 80.7 хувь болгон өсгөж чадлаа.

авснаар өөрийн эзэмшлээ 58 хувиас 68 хувь болгосон юм. Энэхүү хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бид өрийг хувьцаанд хөрвүүлэх байдлаар шийдсэн юм.

2016 онд Ард Кредитын ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэ журмын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгөө 1 тэрбум төгрөгөөр өсгөх шийдвэр гаргасан билээ. Энэхүү арилжаанд бусад хувьцаа эзэмшигчид оролцохгүйгээ мэдэгдсэн бөгөөд Ард Холдингс давуу эрхээ эдлэн санал болгосон хувьцааг бүхлээр нь бүртгэлийн үнийг 1.7 дахин үржүүлсэн үнээр худалдан

Түүнчлэн 2016 оны сүүлээр бид Ард Кредитын 12.7 хувьтай тэнцэх 1,667 ширхэг хувьцааг эзэмшигч Н.Эрдэмбаяраас нийт 570 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд энэ нь бүртгэлийн үнийг 1.8 дахин үржүүлсэн үнэлгээ юм. Үүний үр дүнд бид Ард Кредитын 80.7 хувийг эзэмших болсон ба энэхүү хэлцэл нь 2017 оны эхний улиралд эцэслэгдсэн болно.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн

560 хувьцаа эзэмшигчдийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бий болсон Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК нь 2016 онд нэмж 1 сая ширхэг хувьцаа гарган, үүнээс 700 мянган ширхэгийг нь бид борлуулсан. Үүнээс бид 400 сая төгрөгт нь бид өөрийн хувьцааг солилцсоны үр дүнд Ард Холдингс болон холбогдолтой этгээдүүд нийлээд Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн 32 хувийг эзэмшх болсон юм. Бид оны эцсийн

байдлаар төвлөрүүлсэн нийт 1.7 тэрбум төгрөгийн хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг Засгийн газрын үнэт цаас, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Монгол Шуудан ХК, Ард Даатгал ХХК-ийн хувьцаа, Ард Кредит ББСБ-ийн итгэлцэл зэрэгт байршуулснаар хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз 744 сая төгрөгт хүрч, нийт компанийн үнэлгээ 2.3 тэрбум төгрөг болсон байна.



Санхүүгийн үр дүн ба шинжилгээ



2016 онд компанийн нийт хөрөнгө 3 хувиар буурч 394 тэрбум төгрөг болсон байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцааг худалдсаны дараа бидний өсөлтийн гол хөдөлгүүр нь Монгол Шуудан, Ард Даатгал, Ард Секюритиз болон Ард Кредитэд хийсэн хөрөнгө оруулалтууд болсон билээ. Нийт урт хугацааны хөрөнгө оруулалт 20.8 тэрбум төгрөгөөс 24 хувиар өсч 25.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үндсэн хөрөнгө 21 хувиар буурч 677 сая төгрөг болжээ. Компанийн бусдад олгосон нийт зээлийн багц 194 хувиар өсч 5.4 тэрбум төгрөгт хүрсэн ба энэхүү өсөлтийн гол шалтгаан нь ТТДС-ийн 50 хувиа худалдахтай холбоотой хийгдсэн зээлийн хэлцэлтэй холбоотой юм. Хэлцлийн үр дүнд бид 3 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авсан бөгөөд 1.6 тэрбум төгрөг болон 640 мянган долларын зээлийн гэрээг ТТДС-тай байгуулсан билээ. Зээлийн багцын бусад хэсэг болох 4 тэрбум төгрөгийг Ард Холдингсийн охин компаниудад хувьцаа буцаан худалдан авахад нь гарган өгсөн байгаа.

Бид өр төлбөрөө 67 хувиар бууруулж 6 тэрбум төгрөгөөс 2 тэрбумд хүргэсэн билээ. Үүнээс 712 сая төгрөг нь 3 сард Монгол Шуудан дахь эзэмшлийн хувиа өсгөх зорилготойгоор авсан жилийн 21 хувийн хүүтэй Хаан Банкны зээл байгаа юм. Бид энэхүү зээлийг 2017 оны эхний улиралдаа багтаан төлөхөөр ажиллаж байна. Нийт өөрийн хөрөнгө 8 хувиар өсч 374 тэрбум төгрөгт хүрээд байна. Энэхүү өсөлтийн ихэнх хувийг хэрэгжээгүй ашиг бүрдүүлж байгаа билээ.

Ард Санхүүгийн Нэгдлийн гол орлого нь хүүгийн орлого, ногдол ашиг, охин компаниудаас авдаг түрээс, менежментийн үйлчилгээний төлбөр, хувьцаа борлуулалт болон урт хугацаат хөрөнгө оруулалтыг заран олсон ашиг зэргээс бүрддэг билээ. 2016 оны нийт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ашиг 1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хүүгийн орлого 126 хувиар өсч 476 сая төгрөг болсон үзүүлэлттэй гарчээ. Одоогоор охин компаниудаас ногдол ашиг хуваарилаагүй байгаа боловч бид 2017 ондоо Ард Кредит, Монгол Шуудан болон Ард Даатгалаас ногдол ашиг хүртэхээр төлөвлөж байгаа. Түрээсийн орлого 36 хувиар өсч 177

сая төгрөгт хүрсэн ба энэ нь Ард Даатгал болон Ард Кредит Ард Санхүүгийн Нэгдлийн төв байранд нүүн ирсэнтэй холбоотой юм. Бид өсөн дэвжих тусам бидний зардал даган өсч байгаа бөгөөд үйл ажиллагааны зардал 50 хувь өсч 1.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү зардлын өсөлтийн голлох хэсэг нь компанийн маркетинг 24 хувь, хүний нөөц 113 хувь, удирдлагын зардал 43 хувь, санхүүгийн зардал 41 хувь тус тус өссөнтэй холбоотой юм.

2016 онд төгрөгийн доллартай харьцах ханш 24.7 хувиар унасан бөгөөд бид гадаад валютын урт позицтэй ажилласны хүчинд ханшийн тэгшитгэл дээр нийт 481 сая төгрөгийн ашиг хүртсэн ба энэ нь өмнөх оноос 477 хувиар өссөн үзүүлэлт юм. 2016 оны эцэст Ард Холдингсийн татварын дараах цэвэр ашиг 3.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1,972 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Үүнээс гадна Ард Даатгалын 28 хувийг худалдан авахтай холбогдолтой 716 сая төгрөгийн ашгийг орлогод тооцоогүйг цохон тэмдэглэе.

Компанийн удирдлагын зорилго нь санхүү болон үйл ажиллагааны хувьд компанийг бие даасан болгох байсан бөгөөд энэхүү зорилтдоо бид хүрч чадлаа. Өөрөөр хэлбэл Ард Санхүүгийн Нэгдэл нь толгой компанийн хувьд дангаараа эерэг мөнгөн урсгалтайгаар ажиллах боллоо. Хүү, түрээс, менежментийн төлбөр зэрэг үйл ажиллагааныхаа орлогоор компанийн ажилчдын цалингийн зардал, түрээсийн төлбөр зэрэг зардлуудаа нөхөн ажиллаж байна.

Энэ онд гаргасан бас нэгэн амжилтыг дурдвал 124 тэрбум төгрөгтэй тэнцэх шинэ хөрөнгө оруулалтуудыг одоо байгаа хувьцаа эзэмшигчдэдээ ямар нэг дарамт үүсгэлгүйгээр хийсэн явдал юм. Энэхүү хөрөнгө оруулалтуудын эх үүсвэрийг бид дотоод хүчин чадлаа ашиглан бий болгосон ба хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнэд байж болох хамгийн нөлөө багатай байдлаар шийдсэн юм. Тодруулбал Ард Санхүүгийн Нэгдэл нь дангаараа 14.2 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийсэн ба үүнээс 5.4 тэрбум төгрөгөөр хувьцаагаа эргүүлж авсан билээ.



Хөрөнгө оруулалт болон
зээлийн багц



Монгол Шуудангийн хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2016 оны 1 сарын 8-нд Монгол Шуудан компанийн 17.3 сая ширхэг хувьцааг нэгжийн 185 төгрөгөөр буюу тус компанийн 17.38 хувийг нь нийт 3.3 тэрбум төгрөгөөр худалдан авсан юм. 2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл нийт 989,143 ширхэг Монгол Шуудан компанийн хувьцааг дунджаар 291 төгрөгөөр Ард Даатгал болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн компанид худалдаж 105 сая төгрөгийн ашиг хүртсэн байна. Энэхүү хэлцлүүд нь нэгдэл компанийн хөрвөх чадварын удирдлагын хүрээнд хийгдсэн.

3 дугаар улиралд Ард Санхүүгийн Нэгдэл иргэн Х.Батхишигээс Монгол Шуудан компанийн 9,068,946 ширхэг хувьцааг нэгжийг 326 төгрөг болон 2,045,328 ширхэг хувьцааг 333 төгрөгөөр нийт хувьцааны 11.16 хувийг хоёр тустаа арилжаанд оролцон нэмж авсан. Хувьцааны төлбөрт Ард Санхүүгийн Нэгдлийн нэгж хувьцааг 1,750 төгрөгөөр тооцон 2.95 тэрбум төгрөгийн хувьцаа болон 680 сая төгрөгийг бэлэн мөнгөөр өгсөн байна. Одоогоор бид Монгол Шуудангийн 27.55 хувийг шууд эзэмшиж байгаа ба охин болон хараат компаниудын эзэмшлийг нэмвэл нийт 30.56 хувийг эзэмшиж байна.

Монгол Шуудангийн хөрөнгө оруулалтын үзүүлэлт

Ард Санхүүгийн Нэгдэл 6.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр Монгол Шуудангийн 27.4 сая ширхэг хувьцаа буюу 27.55 хувийг эзэмшиж байна. Нэгж хувьцааны дундаж өртөг 242.6 төгрөг байгаа бөгөөд Монгол Шуудангийн хувьцаа 2016 оны эцэст 339.8 төгрөгөөр хаагдсанаар бидний хөрөнгө оруулалтын үнэлгээ 9.32 тэрбум төгрөгт хүрч, 40 хувийн хөрөнгө оруулалтын ашигтай буюу нэгж хувьцаанаас 97.2 төгрөгийн ашиг хүртээд байна.

Ард Даатгал болон Хөрөнгө Оруулагч Үндэстэнд 989,143 ширхэг Монгол Шуудангийн хувьцааг арилжаалснаар 105 сая төгрөгийн хэрэгжсэн ашигтай ажиллав. Нэгж хувьцааны үнийн өсөлтөөс хөрөнгө оруулалтын өгөөж хүртсэнээс гадна, Монгол Шуудангийн үйл ажиллагаа нь сайжирч 2015 онд 94 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2016 онд 1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Ард Санхүүгийн Нэгдэл нь 2017 оны эхний хагаст 82.6 сая төгрөгийн ногдол ашиг хүртэхээр байна.

Ард Даатгалын хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгалын үйл ажиллагаа болон сангийн удирдлагын хяналтаа ихэсгэх үүднээс өөрийн эзэмшлийн хувиа 55.31 хувиас 83 хувьд хүргэсэн. Ард Санхүүгийн Нэгдэл нь Блю Планет ХХК-ас 16.72 хувийг, мөн ДЧулуунцэцгээс 11 хувийг тус тус худалдан авсан юм. Нийт 413,690 ширхэг Ард

Даатгалын хувьцааг 2.2 тэрбум төгрөгөөр авсан ба уг хэлцэлд үл хөдлөхийн солилцоо, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа болон бэлэн мөнгө оруулсан билээ. Ингэсний үр дүнд бид энэхүү хэлцлээс нэг удаагийн 716 сая төгрөгийн биелээгүй ашиг хүртэж чадсан.

Ард Даатгалын хөрөнгө оруулалтын үзүүлэлт

Ард Даатгал нь 2015 онд 138.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2016 онд даатгалын үйлчилгээний борлуулалтаа нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа сайжруулан зардлаа хассаны үндсэн дээр 431 сая төгрөгийн ашигтай

ажилласан. Ард Даатгалын ашигт ажиллагаа болон үйл ажиллагаа сайжирснаар тус компанийн үнэлгээ 6.3 тэрбум төгрөгөөс 7.7 тэрбум төгрөг болж өслөө. Бид Ард Даатгалаас ногдол ашиг хүртэхээр төлөвлөж байна.

Ард Кредитын хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Кредит компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээс гадна, нэмж 12.7 хувь буюу 1,667 ширхэг хувьцааг бүртгэлийн үнээс 1.8 дахин нэмэгдүүлсэн дүнгээр иргэн Н.Эрдэмбаяраас 570

сая төгрөгөөр худалдан авснаар өөрийн эзэмшлийн хувиа 58 хувиас 80.7 хувь болгон нэмэгдүүллээ. Энэхүү хэлцэл нь 2017 оны эхний улиралд эцэслэгдсэн.

Ард Кредитын хөрөнгө оруулалтын үзүүлэлт

Ард Кредитын үнэлгээ 2014 онд 1.85 тэрбум төгрөг байсан бол сүүлийн арилжааны дараа 218 хувиар өсч 2016 оны эцэст 5.9 тэрбум төгрөгт хүрлээ. Энэхүү үнэлгээний өсөлт нь Ард Санхүүгийн Нэгдлийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын хэмнэлт болон зээлийн багцын чанарын

үзүүлэлттэй шууд холбоотой юм. Ард Кредит 2017 онд зээлийн багцаа өсгөж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэн ажиллахыг зорьж байна. Мөн тус компани нь олон нийтэд хувьцаагаа санал болгон нээлттэй хувьцаат компани болон ажиллахаар төлөвлөж байна.

Ард Секюритиз

Ард Санхүүгийн Нэгдэл нь Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагын дагуу Ард Секюритиз ҮЦК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 1.5 тэрбум төгрөгөөр өсгөж дотооддоо тэргүүлэх брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч үнэт цаасны компани болохоор ажиллаж байна. Санхүүгийн Зохицуулах Хороо нь энэхүү хөрөнгө оруулалтыг 2017 оны 1 сард баталсан билээ.

Тус компанийн ашиг 2015 онд 73 сая төгрөг байсан бол 2016 онд 157 сая төгрөгт хүрлээ. Ард Секюритиз нь 491.6 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байгаа боловч 1.5 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлснээр компанийн үнэлгээ 2.1 тэрбум төгрөг болж өслөө.

ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс гарав

Ард Санхүүгийн Нэгдэл нь ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн үлдсэн 4.28 хувийн хувьцаагаа 12.36 тэрбум төгрөгөөр 2015 онд зарах хэлцлийг хийсэн юм. Бид 2008 оноос өмнө ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцааг 2.86 тэрбум төгрөгөөр худалдан авч байсан.

2008 оныг суурь жилээр авбал Ард Санхүүгийн Нэгдлийн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл дэх хөрөнгө оруулалтын өгөөж сүүлийн 8 жилийн турш 332 хувь буюу жилийн 41 хувийн өгөөжтэй байсан ажээ.

ТТДС-ийн хөрөнгө оруулалтыг зарав

Ард Санхүүгийн Нэгдэл нь Техник Технологийн Дээд Сургуульд хөрөнгө оруулан 8 жилийн дараа хөрөнгө оруулалтаа худалдан гарлаа. Бид 2006-2008 онд тус сургуулийн 50 хувийг 1.92 тэрбум төгрөгөөр худалдан авч байсан бол 2016 онд 9.82 тэрбум төгрөгөөр зарж 411 хувь, жилийн 51 хувийн хөрөнгө оруулалтын өгөөжтэй ажиллалаа. Энэхүү арилжаа Ард Санхүүгийн Нэгдэл хувьцаагаа эргүүлэн худалдан авах, үл хөдлөх хөрөнгө авах

болон зээл олгох байдлаар хийгдсэн. Хэдийгээр Ард Санхүүгийн Нэгдэл нь Техник Технологийн Дээд Сургуулиас бэлэн мөнгө авч чадаагүй ч гэсэн 50,000 долларын Хүннү бондоор эхний зээлийн эргэн төлөлт орж ирсэн байна. Бид үлдэгдэл зээлийн зарим төлбөрт үл хөдлөх хөрөнгө мөн газар авахаар хэлэлцэж байна.

Ард Санхүүгийн Нэгдлийн зээлийн багц

Ард Санхүүгийн Нэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 5.3 тэрбум төгрөгийн зээлийг төгрөг болон доллароор олгосон байна. Нийт зээлийн 90 хувийг Номын хишиг, Техник

Технологийн дээд сургууль болон Ард Секюритиз компаниуд эзэлж байна. Доорх хүснэгтээс Ард Санхүүгийн Нэгдлийн олгосон зээлийн задаргааг харна уу.

Зээлдэгч	Зээлийн үлдэгдэл (төгрөг)	Зээлийн үлдэгдэл (доллар)	Хүү
Номын Хишиг		\$750,000	12%
ТТДС	1,579,541,250.10		10%
ТТДС		\$639,482	8%
Бусад	272,085,059.44		

Бусад хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь Хийморь хотхонд 3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 3 таун хаусыг эзэмшиж байна. 2017 ондоо бид эдгээр таун хаусуудыг Ард Менежментийн Үл Хөдлөх Хөрөнгийн санд шилжүүлэхээр төлөвлөж байна. Мөн бид 20,000 долларын

Хүннү Бондыг эзэмшиж байсан ба нэмж ТТДС-аас зээлийн эргэн төлөлт болгож 50,000 долларыг 2017 оны 1 сард авсан. Бондын эргэн төлөлт хугацаандаа төлөгдөж байна.

Хувьцааны арилжаа

2016 онд бид Ард Санхүүгийн Нэгдлийн 2,758,435 ширхэр хувьцааг нийт 5.4 тэрбум төгрөгөөр эргүүлж худалдан авсан бол 3,624,765 ширхэг хувьцааг нийт 6.3 тэрбум төгрөгөөр хувьцааг эргэлтэнд орууллаа. Үүн дээр 1,737,633 ширхэг нийт 2.5 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа манай хувьцаа эзэмшигчдийн хооронд явагдсан байна. Одоогийн байдлаар бид 1,602,164 хувьцааг халаасалж, мөн 3,103,409 хувьцааг охин компаниудаараа дамжуулан эзэмшиж байгаа болно.

Ард Холдингсын хувьцаа Ард Секюритизээр дамжуулан хаалттай хүрээнд арилжаалагддаг ба 2016 онд 8,120,833 ширхэг нийт 14,220,791,691 төгрөгийн арилжааг гүйцэтгэжээ. Монголын Хөрөнгийн Биржийн мэдээлснээр 2016 онд нийт 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжжээ. Ингэж харвал Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа МХБ-ийн нийт хувьцааны арилжааны 29 хувьтай тэнцэж байна.

Дараачийн алхам

Бид 2017 ондоо багтаж Хөрөнгө Оруулагч Үндэстэн болон Жинст Увс хоёрыг нэгтгэж хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болохоор ажиллаж байгаа ба цаашлаад барууны хөрөнгийн бирж дээр гарах боломжийг хайж байна.

Ард Санхүүгийн Нэгдлийн хөгжлийн дараагийн шатанд Хил Хязгааргүй Банкирууд уриан дор дижитал хувьсгалыг хийх болно. Бид Монгол Шуудангийн түншлэлийнхээ хүрээнд цахим худалдаа болон тээвэр логистикийн үйл ажиллагааг нэвтрүүлж Монголын эдийн засгийг Аж үйлдвэрийн дөрөв дэхь хувьсгал руу хөтлөхийг зорьж байна.

Ард Базаар гэдэг нь, манай өдрөөс өдөрт өсөж буй хөрөнгө оруулагч нарт өөрсдийнхөө бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлах боломжийг олгох цогц цахим зах, худалдаа эрхлэх газар юм. Бид P2P буюу “хүнээс хүнд” зээл олгох платформыг

хөгжүүлж байгаа ба блокчэйны технологийг судлан криптовалютыг зах зээлд нэвтрүүлэх боломжийг хайж байна. Ингэснээр бид үндэсний хамгийн анхны Финтек банкиг босгохыг зорьж байна. Ард Кредит нь ойрын хугацаанд ББСБ болон жижиг банкуудад Апекс зээлдэгч болохоор зорин ажиллаж байна. Урт хугацаанд Ард Кредит нь банкны лиценз авах зорилгыг дэвшүүлсэн. Мөн бид тус компанийг Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг хамгийн анхны ББСБ болгох боломжийг судлаж байна.

Ард Менежмент нь тэтгэврийн болон даатгалын сангуудыг удирдахаас гадна үл хөдлөх хөрөнгийн сан, өмч хувьчлалын санг босгох боломжтой юм. Ард Секюритиз нь үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын банкны зөвлөхийн үйлчилгээ үзүүлдэг тэргүүлэгч байгууллага болохын төлөө ажиллана.

Тайлангийн дараа өрнөсөн үйл явдал

- 19.2 хувийн купонтой 24 сарын хугацаатай 2 тэрбум төгрөгийн бондыг хаалттай хүрээнд амжилттай гаргалаа. Энэ шинэ эх үүсвэрээр бид банкны зээл, бусад өр, татварын өглөгөө барагдуулж үлдсэнийг нь Ард Кредитэд зээлдүүлэв.
- ТТДС-ийн зээлнээс 1,032 сая төгрөгөөр байшин болон газар худалдан авах гэрээг хийв.
- Ард Секюритизийн шинэ 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөв.
- Ард Кредитын 1 тэрбумын төгрөгийн шинэ хөрөнгө оруулалтыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөв. Бид үүн дээр нэмж авсан 12 хувийн 570 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг хүлээж байна.
- Хөрөнгө Оруулагч Үндэстэн болон Жинст Увс хувьцаат компаниудын нийлэх хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэв.
- Ард Кредитын кобренд кредит карт гарав.
- Ард Актив өөрийн даатгагдсан хадгаламжийн бүтээгдэхүүнээ сурталчилж эхэллээ.
- Монгол Шуудангийн ТУЗ 300 сая төгрөгийн (30 хувь) ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэв. Ард Кредитын ТУЗ 200 сая төгрөгийн (50 хувь) ногдол ашиг хуваарилав. Ард Даатгалын ТУЗ 4 сард хуралдаж ногдол ашиг хуваарилна.
- ТУЗ-ийн албан бус хэлэлцүүлгийг 2 сард хийж Ард Банкныг байгуулах ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэв.
- Манай ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал 4 сард болж өнгөрлөө. Хувьцаа эзэмшигчид 7 ердийн гишүүн (Ж.Оюунгэрэл, Бруно Рашле, Антони Хоброу, Ч.Ганхуяг, Ц.Ариунтөгс, Х.Батхишиг, Ч.Номин) болон 4 хараат бус гишүүдийг (П.Батбаяр, О.Одбаяр, Л.Соронзонболд, Н.Мөнхнасан) гишүүдийг тус тус сонголоо. Манай ТУЗ-н бүрэлдэхүүнд шинээр 2 эмэгтэй гишүүн болох Ч.Номин (МонголТВ), Н.Мөнхнасан (Монполимет) нар нэмэгдсэнийг дурьдахад таатай байна.



Охин компаниудын тайлан



Ард Даатгал ХХК



2016 оны эцсээр компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл өөрийн эзэмшиж буй хувийг 83.03 хувьд хүргэлээ. Мөн шинээр Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК хувьцаа эзэмшигч Н.Эрдэнэтулгын эзэмшиж байсан 2 хувийг худалдан авч, хувьцаа эзэмшигчийн эгнээнд нэгдэн орлоо. Үүнтэй холбоотой компанийн ТУЗ-ийн бүтцэд мөн өөрчлөлт орж, олон жил компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Д.Чулуунцэцэг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөн, түүний оронд хараат ТУЗ-өөс хараат бус гишүүний тоог нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу МонПолимет ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхнасанг ТУЗ-ийн гишүүнээр ажиллах санал тавьж, ТУЗ-ийн зүгээс бүрэн дэмжсэн билээ.

Ард Даатгал ХХК нь 2016 онд төв компани болон нийт 23 салбар, 400 орчим даатгалын төлөөлөгч, 19 даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллаж, 7.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлж, 1.3 тэрбум төгрөгийг давхар даатгалд төлж, 5.7 орчим тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготой ажиллалаа. Бид өнгөрсөн онд нийт 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон.

2016 оны 7 дугаар сард Ард Даатгал нь UIB давхар даатгалын брокероор дамжуулан трити хамгаалалт авсан бөгөөд давхар даагчаар Hannover Re, Scor Re зэрэг нэр хүнд бүхий олон улсын давхар даагч нар оролцсон. Трити гэрээг бид цаашид үргэлжлүүлэн хийх бөгөөд компанийн эрсдэл даах чадвар нэмэгдсэнээр давхар даатгалд шилжүүлэх эрсдлийн заримыг дотооддоо үлдээх, улмаар орлогоо нэмэх боломжтой юм. Компани жилийн дундуур даатгалын брокеруудтай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулж, шимтгэлийн хэмжээг бууруулж чадсан. Жолоочийн даатгалын хураамж өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 0.8 дахин буурсан бөгөөд нийт хураамжийн орлогын 24.6 хувийг эзэлж байна. Үүнийг дагаад нөхөн төлбөр мөн өнгөрсөн онтой харьцуулбал 0.6 дахин буурсан үзүүлэлттэй

байгаа ба жолоочийн даатгалтай холбоотой нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 39.6 хувьтай тэнцүү байна.

Бид харилцагчийн үйлчилгээг түргэн шуурхай болгох үүднээс өөрийн гэсэн шуурхай албыг үүсгэн байгуулж, даатгалын тохиолдол болсон газарт түргэн шуурхай хүрч, харилцагчиддаа зөвлөгөө өгч ажилласнаар үйлчилгээний чанар, хурд сайжирсан.

2016 оны хувьд компанийн нийт хөрөнгө 9.54 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулбал 782.62 сая төгрөг буюу 8.94 хувиар өссөн байна. Хөрөнгө оруулалтын орлогын хувьд 801 сая төгрөгийн орлого олсон бөгөөд өмнөх оноос 38 хувиар өссөн байна.

2016 онд компани нийт 431 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Компанийн өөрийн хөрөнгийн өгөөж 10.2 хувь, хөрөнгийн өгөөж 4.5 хувь байна. Хохирлын хувь өнгөрсөн онтой харьцуулбал 13.4 хувиар сайжирч, оны эцсээр 36 хувь хүрсэн бол зардлын хувь 53 хувь болсон байна.

Ард Даатгал нь Ард Санхүүгийн Нэгдэл болон группын бусад компаниудын салбар сүлжээг ашиглан борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлэх ажиллалаа. Ард Лайф ХХК-аас санал болгож буй тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүнд эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалыг багтаан иргэдэд санал болгосноор энэхүү бүтээгдэхүүний борлуулалтад үлэмж нөлөөлнө гэдэгт итгэлтэй байна. Ард Кредит компанийн гаргаж буй зээлийн бүхий л бүтээгдэхүүн дээр даатгалын үйлчилгээг хамт үзүүлж байна. Ард Кредитын гаргасан зээлийн эрхтэй картын үлдэгдлийг мөн даатгалд хамруулснаар кредит картын борлуулалт мөн нэмэгдэнэ. 2017 оноос Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар даатгалын борлуулалтыг эрчимжүүлэх талаар яриа хэлэлцээрүүд амжилттай явж, тус компанийн ТУЗ-өөс энэхүү санаачлагыг бүрэн дэмжсэн болно.



Ард Кредит ББСБ



Хэдийгээр 2016 оны эдийн засаг, нийгмийн байдал сайнгүй байсан ч манай компанийн хувьд нийт хөрөнгө 22 хувь, эзэмшигчдийн өмч 74 хувь, зээлийн багц 38 хувиар тус тус өсч татварын дараах цэвэр ашиг 401.8 сая төгрөг буюу 19 хувийн дундаж өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан жил болон өнгөрлөө. Бид нийт 5.5 тэрбум төгрөгийн зээлийг 379 удаагийн олголтоор хийж нийт 382 харилцагчидтай болон ажиллалаа.

Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш компанийн засаглал, ил тод байдал, нийгмийн хариуцлагын хувьд зах зээл дээр тэргүүлэгч байхыг эрмэлзэн ажиллаж ирсэн билээ. Тайлант хугацаанд бид нийт 7 удаагийн ТУЗ-ийн хурлыг зохион байгуулсан бөгөөд ТУЗ-ийн хороодын хурал болон дотоод аудитын ажлыг идэвхжүүлэн, тогтворжуулж ажиллалаа. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Дэлхийн эдийн засгийн форумын залуу манлайлагчдын нэг В.Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр урин ажиллуулж эхэлснээр манай ТУЗ 2 хараат бус, нийт 7 гишүүнтэйгээр ажиллах боллоо.

2017 онд манай компани хувь нийлүүлсэн хөрөнгөө төлөвлөж байсныхаа дагуу 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл (Ард Санхүүгийн Нэгдэл) дангаараа шинээр гаргасан хувьцааг худалдан авсан билээ. Түүнчлэн манай хувьцаа эзэмшигч Н.Эрдэмбаяр өөрийн эзэмшлийн хувьцаагаа

Ард Санхүүгийн Нэгдэлд бүхэлд нь худалдсанаар Ард Санхүүгийн Нэгдэл нийт компанийн 80.7 хувийг дангаараа эзэмших боллоо. Хувьцааны үнэлгээг тооцохдоо бүртгэлийн үнийг 1.7 дахин үржүүлсэн үнээр хийсэн гэдгийг цохон тэмдэглэе.

Компанийн Алсын хараанд дурдсаны дагуу бид ямагт зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, харилцагчидтайгаа илүү ойртон ажиллахыг зорин ажилладаг билээ. 2016 онд манай багийн шаргуу хөдөлмөрийн үр дүнд Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)-тай хамтарсан кредит картаа гаргах ажлаа эцэслэж, зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд харилцагчиддаа цахимаар картаа захиалан авах боломжийг олгож www.ardcard.mn хуудсыг нээлээ. Ингэснээр бид ББСБ-ын салбартаа олон нийтэд зориулсан кредит карт гаргасан анхны байгууллага болсон бөгөөд харилцагчдынхаа талархлыг хүлээн ажиллаж чадсан юм.

2017 онд эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сэргэж, цаашид тогтвортойгоор өсөн сайжрах нөхцөл бололцоо бүрэлдэж байгаа хэмээн харж байна. Иймд манай компани 2017 онд урд өмнөх жилүүдээс илүү өндөр амжилт гарган ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд ойрын ирээдүйд бүх төрлийн банкны үйлчилгээг Монгол улсын ард иргэдэд хүргэдэг болох зорилготой байна.



Ард Секюритиз УЦК



Ард Секюритиз УЦК ХХК нь 2016 онд борлуулалтын орлогоо нэмэгдүүлэн ажиллахын зэрэгцээ үйл ажиллагааны зардлын харьцааг тогтвортой барьж, орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 140 хувь, цэвэр ашиг 137 хувиар тус тус өсгөн амжилттай ажилласан байна.

Бидний амжилтын гол түлхүүр нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн тогтвортой өсөлт, шинээр харилцагч татах чадвар болон үнэнч харилцагчдынхаа итгэлийг даан тэдний хэрэгцээнд тохирсон үйлчилгээг санал болгон ажилладагт оршино.

Мөн бид 2016 онд боловсон хүчиндээ онцгой анхаарч доороос дээш бүх шатандаа чадвартай, мэргэшсэн боловсон хүчин нэмж ажиллуулснаар хөдөлмөрийн бүтээмжийг эрс сайжруулсан төдийгүй компанийн ашигт ажиллагааг өсгөсөн. Ард Секюритиз УЦК ХХК ойрын хугацаанд Ард Санхүүгийн Нэгдэл-ийн хөрөнгө оруулалтын багцын хамгийн өндөр өгөөжтэй охин компани болох төлөвлөгөөтэй байна.

2016 оны 12 сард Хүннү Эйр ХХК-ийн 1.5 тэрбум төгрөгийн бонд гарган андеррайтераар ажиллаж дотоодын хөрөнгийн зах зээлээс амжилттай санхүүжилт татаж чадсан. 2017 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компани Ард Кредит ББСБ-ын зээлийн багцыг нэмэгдүүлэх зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2 тэрбум төгрөгийн бонд дээр андеррайтераар ажиллан санхүүжилт татахаар төлөвлөж байна.

Ард Секюритиз УЦК нь бонд гаргах болон Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй хувьцаат компани болох сонирхолтой компанид андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлж амжилттай санхүүжилт татах боломжийг бүрдүүлж

Монгол улсын тэргүүлэх брокер, диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхэлдэг компани мөн гэдгээ нотлон ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллахын зэрэгцээ санхүүгийн боловсрол олгох зорилготойгоор байгуулагдсан Ард Академи нь 7 хоног бүр хөрөнгийн зах зээлийн талаар сургалт зохион байгуулж, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулах боломжтой бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгосоор байна. Өнөөдрийн байдлаар 1,200 гаруй хүн манай сургалтанд хамрагдан хувьцаа, бонд худалдан авч хадгаламжийн хүүгээс өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийж байгаа. Сургалтанд хамрагдсан ихэнх хүмүүс Ард Санхүүгийн Нэгдэл-ийн хувьцаа эзэмшигч, Ард Лайф компанийн хувийн тэтгэврийн сангийн харилцагч болсон байдаг нь бид харилцагчдынхаа хэрэгцээнд тохирсон зөв хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гаргадагт оршино.

Бид харилцагчдын нэгдсэн мэдээллийн санг үүсгэн, мэдээ мэдээлэл солилцох Харилцагчийн Уялдаа Холбооны Систем (CRM) гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон подкаст сувгийг ашиглан үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлж борлуулалтаа өсгөж байна.

Ард Секюритиз УЦК-ийн цаашдын зорилго нь арилжааны банк, Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компанийн хувьцаа, бонд дээр мэргэжлийн түвшний үнэт цаасны шинжилгээ хийж, харилцагчдад үнэн бодит судалгаа дээр тулгуурласан санхүүгийн зөвлөгөө, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг мэдээлэл өгч тэдэнд үнэ цэнэ нэмж чадах бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллах болно.



Монгол Шуудан ХК



2016 оны 1 сарын 8-нд УИХ-ын 70, ЗГ-ын 330, ТӨХ-ны 594-р тогтоолыг тус тус үндэслэн Монгол Шуудан ТӨХК-ийн 34 хувийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хувьчилсан билээ. Нэгж хувьцааг 185 төгрөгөөр үнэлэн нийт 33,859,363 ширхэг хувьцааг шинээр Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргаж, нийт 6,263 сая төгрөгийг компанид төвлөрүүлсэн байна.

Хувьчлалын дараа удирдлагын баг өөрчлөгдөн компанийнхаа шинэ стратегийг чиглэлийг 12 сард гаргаж батлуулав. Үндсэн үйл ажиллагаа болох шуудан хүргэлтийн үйлчилгээнээс гадна логистик, санхүүгийн үйлчилгээг үзүүлэхээр тогтлоо. Шинээр гаргасан стратегидаа хүрэхийн тулд удирдлага зохион байгуулалт, технологи, бүтээгдэхүүн болон компанийн соёлдоо шинэчлэлтийг хийх шаардлагатай гэж бид үзэж байна.

Хувьцааны ханш 12 сарын арилжааны сүүлийн өдөр 339.86 төгрөгт хүрч, нийт 99,586,363 ширхэг хувьцаатайгаар компанийн зах зээлийн үнэлгээ 33,845,421,329 төгрөгт хүрсэн байна.

2016 онд нийт орлого 11,923 сая төгрөгт хүрч өмнөх оныхоос 18 хувь буюу 1,829.90 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс хүүгийн орлого, транзит үйлчилгээ болон ханшийн зөрүүний олз нийлээд нийт орлогын 16 хувь буюу 1,946.6 сая төгрөг болж голлох нөлөө үзүүлсэн байна.

Монгол Шуудангийн EMS буюу буухиа шуудангийн үйлчилгээг өргөжүүлэн EMS солилцдог орны тоог 38-аас 191 болгож зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Компанийн стратегид тусгагдсаны дагуу бид үндсэн үйлчилгээ болох хүргэлтийн үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дотоод гадаадын и-худалдааны логистик, тээвэр зууч болон нэгдсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

2016 онд Монгол Шуудан ХК нь улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээний чанарын үзүүлэлтээрээ Дэлхийн шуудан холбооноос Алтан өргөмжлөлөөр шагнуулсан байна. Мөн бид Монголын ТОП-100 аж ахуй нэгжийн нэгээр шалгарч ажиллалаа.



ТэнГэр Системс ХХК



Хадгаламж зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагад хэрэглэгддэг гол бүтээгдэхүүн болох Genius Banker програмын шинэчилсэн хувилбарыг амжилттай гаргалаа. Genius Banker-ын шинэчилсэн хувилбар нь олон хэрэглэгчдийг татаж чадсан бөгөөд бид зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулан түүнийхээ дагуу ажиллаж эхэллээ.

Үүний хажуугаар 2017 оны зун банк бус санхүүгийн байгууллагуудад зориулагдсан Jupiter програмыг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

2016 оны зунаас эхлэн Тэнгэр Системс нь Их Британийн стартап компани болох what3words-ын Монгол дахь албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж эхэллээ. what3words нь дэлхийн хаягжилтын шинэлэг систем бөгөөд дэлхийн мэдээллийн технологийн бизнест эрчимтэй өсч буй гарааны бизнес юм. Тэнгэр Системс болон what3words хамтран энэхүү хаягжилтын системийг Монголд нутагшуулахаар ажиллаж байгаа бөгөөд

энэ системийг дэлхий дахинд өргөжин нэвтрэхэд Монгол улс чухал үүрэг гүйцэтгэх юм.

2017 онд бид Ард Санхүүгийн Нэгдэл болон салбар компаниудад дижитал маркетинг, дизайны шийдлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн юм.

Тэнгэр Системс нь менежментийн шинэчлэл хийн сайжруулсан бодлого төлөвлөлттэйгээр ажиллаж эхлээд байна. 2016 оны сүүлээр томилогдсон гүйцэтгэх захирал Б.Намнандоржийн удирдлаган дор бид хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг зорин ажиллах болно. Бид чадварлаг IT инженер болон дизайнеруудаар нэмж багаа чадваржуулах ажлыг эхлүүлээд байна.

Мөн Тэнгэр Системс нь Ард Санхүүгийн Нэгдэл-д Дижитал Хувьсгал хийхэд гол үүрэг гүйцэтгэх бөгөөд ингэснээр Ард Холдингс хэрэглэгчиддээ илүү хурдан, найдвартай, хямдаар үйлчилгээгээ хүргэх боломжтой болох юм.



Ард Лайф ХХК



Өнгөрсөн хугацаанд Монголын ууган тэтгэврийн сан болох МТНД ХХК-ийн үйл ажиллагааг Ард Актив ХЗХ үргэлжлүүлж, Ард Холдингсын нийт ажилчдад тэтгэврийн хуримтлалын үйлчилгээг үзүүлж ирсэн билээ.

2016 оны 3 дугаар улиралд хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тэтгэврийн сангийн үйл ажиллагааг МТНД ХХК руу буцаахаар шийдвэрлэсэн ба үүнтэй холбоотойгоор компанийн стратеги, төлөвлөгөө болон тэтгэврийн дансны бүтээгдэхүүний нөхцлийг өөрчлөхөөр болсон юм.

Ийнхүү 2016 оны 11 сард тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүний багцыг шинэчилж хуримтлал, хөрөнгө оруулалтын нөхцлүүдийг багтааснаас гадна эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай хослуулсан шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулснаар сар хагасын хугацаанд тэтгэврийн сангийн харилцагчдын тоо 150-аар, борлуулалтын орлого 80 хувиар өслөө.

Мөн Ард Секюритиз ҮЦК-ас зохион байгуулдаг Ард Академийн сургалтаар дамжуулан иргэдэд хувийн тэтгэврийн сангийн тухай мэдээлэл, танилцуулгыг тогтмол хүргэж, тэтгэврийн хуримтлалын үр ашгийг ойлгуулахад анхааран ажиллаж байна. Тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүний давуу тал нь Улсын тэтгэврийн даатгалын бүхий л сул талыг нөхөхөөс гадна, өөрсдийн бүрдүүлэх хөрөнгө оруулалтын багцыг санал болгосноор харилцагчид шууд бус замаар хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож хөрөнгө оруулалтын өгөөжөөс хүртэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Өнгөрсөн онд бид стратеги төлөвлөгөөгөө шинэчилсний дагуу

урт болон богино хугацааны хөрөнгө оруулалтуудыг хийж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт хөрөнгө оруулалтын багцад хугацаат хадгаламж, Засгийн газрын үнэт цаас болон Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Монгол Шуудан ХК-ийн хувьцаа багтаж байна.

2017 онд бид тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүн, үйлчилгээгээ илүү боловсронгуй болгож, дэвшилтэт технологийг ашиглан харилцагчдаа тогтмол мэдээллээр хангах, компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулахад анхаарлаа хандуулж ажиллахаас гадна Улсын тэтгэврийн тогтолцоог шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа өнөө үед Хувийн тэтгэврийн сангийн тухай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх ажилд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болно.

2016 оны эцсээр МТНД ХХК-ийн нэрийг сольж, Ард Лайф болгохоор шийдвэрлэсэн ба цаашид тэтгэврийн сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, өргөжүүлэх зорилгоор Ард Холдингсын зүгээс 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр болсон юм. Мөн олон улсын жишгийн дагуу Кастодиан банкттай хамтран ажиллаж хөрөнгөө хадгалуулахаар төлөвлөж байна. Ингэснээр хөрөнгийн хяналт сайжрахад гадна харилцагчдын хөрөнгийн бүртгэл, тооцоолол илүү боловсронгуй болох боломжтой. Цаашид хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Ард Менежмент компани тэтгэврийн сангийн удирдлагыг хэрэгжүүлэх ба ингэхдээ Ард Секюритиз ҮЦК-ийн шинжээчдийн хийсэн зах зээлийн судалгаа шинжилгээнд үндэслэн үр ашигтай хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлж, харилцагчдынхаа өгөөжийг нэмэгдүүлэх болно.



Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК



Хөрөнгө Оруулагч Үндэстэн компани нь 2016 оны нэгдүгээр сард ирээдүйдээ хөрөнгө оруулж, Монгол орныхоо баялгийн эзэн болохоор сэтгэл шулуудсан 560 иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор анх удаагаа Фэйсбүүкээр дамжуулан олон нийтийн санхүүжилтийн аргачлалаар (краудфандинг) үүсгэн байгуулагдсан билээ. Анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаараа бид Чингис хааны аравтын системийг ашиглан ТУЗ-өө нийт хувьцаа эзэмшигчдийнхээ дундаас нээлттэйгээр сонгон шалгаруулж томилсон юм. Тус хурлаар компанийн урт хугацааны зорилтоо дэвшилтэт технологи дээр үндэслэсэн Монголын анхны ард түмний банкийг үүсгэн бий болгох гэж тодорхойлсон. Олон нийтэд зориулсан цуврал санхүүгийн сургалт, 21 аймгийг хамарч эхэлсэн лекц танилцуулга, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал ертөнцөөр хийсэн маркетингийн ажлын үр дүнд манай хувьцаа эзэмшигчдийн тоо 2016 оны сүүлээр 850-д хүрсэн юм.

Манай хөдөлгөөнд нэгдэх сонирхолтой хувь хүн болон байгууллагын эрэлт нэмэгдэх хэрээр бид 2016 онд нэмж 1 сая ширхэг хувьцаа гаргасан ба нийт 700 гаруй сая төгрөгийн

нэмэлт хөрөнгө оруулалт татаж чадсан байна. Ингэснээр манай нийт эздийн өмч 1.7 тэрбум төгрөгт хүрч, энэхүү хөрөнгийг Засгийн газрын үнэт цаас, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (7 хувь), Монгол Шуудан ХК (0.2 хувь), Ард Даатгал ХХК (2 хувь)-ийн хувьцаа, Ард Кредит ББСБ-ын итгэлцэл зэрэгт оруулснаар хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз 744 сая төгрөг, нийт компанийн үнэлгээ 2.3 тэрбум төгрөгт хүрлээ. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй нэгж хувьцааны дотоод үнэлгээ нэг жилийн дотор 50 орчим хувиар нэмэгдэж 1,473 төгрөг болж чадлаа.

Манай компанийн дараагийн том зорилтот ажил бол Жинст Увс ХК-тай нэгдэж Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй арилжаалагддаг компани болох явдал юм. Хоёр талаас холбогдох ажил гүйлгээ хийгдэн нэгдэх үйл явц сүүлийн шатандаа явж байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компани болсноор манай хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэн бид хамтдаа ард түмний банк байгуулах зорилгодоо нэг том алхмаар дөхөж очих юм.



Ард Актив ХЗХ



2016 оны үйл ажиллагааны үр дүнд манай хоршооны нийт хөрөнгө 20 хувиар, хадгаламжийн багц 26 хувиар, зээлийн багц 50 хувиар тус тус өссөн ба нийт гишүүдийн тоо 789-д хүрч өмнөх онтой харьцуулахад 45 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд бид Хоршооны дотоод бүтэц, удирдлага болон бүтээгдэхүүн үйлчилгээний багцдаа хэд хэдэн томоохон өөрчлөлт оруулсны нэг нь нийт хадгаламжийн багцын 1/3 хэсгийг эзлэх Хувийн Тэтгэврийн Сангийн бүтээгдэхүүнээ Ард Лайф компанид шилжүүлсэн явдал байлаа. Үүнтэй холбоотойгоор Хоршооны цаашдын зорилго, хүрэх цэгээ дахин тодорхойлж, шинэчлэгдсэн төлөвлөгөөний дагуу анхны жишиг Хадгаламж Зээлийн Хоршоо болохоор зорин ажиллах болов.

2016 оны 5 дугаар сард мөнгөн гүйлгээний системийг шинээр нэвтрүүлж, гишүүн иргэд болон байгууллага хоорондын мөнгөн шилжүүлэг, бэлэн төлбөр тооцоо, хадгаламжийн орлого, зарлагын гүйлгээ зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай үзүүлдэг болсон нь манай Хоршооны үйлчилгээг нэг шатаар ахиулсан явдал байлаа. Үүнээс гадна

бид гишүүдийнхээ өдөр тутмын гүйлгээ, аливаа төлбөр тооцоог зөвхөн Хоршоон дахь дансаа ашиглан гүйцэтгэх, мөн цахим хэлбэрээр өөрсдийн дансаа удирдах боломжийг олгохоор судлан ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Тайлант хугацаанд бид нийт 158 гишүүнд 836.9 сая төгрөгийн зээл олгосноос 85 хувийг хувь хүнд олгосон хэрэглээний зээл, 15 хувийг бизнесийн зээл тус тус эзэлж байна. 2016 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 2 хувь нь чанаргүй зээл байгаа ба 2017 онд зээлийн эрсдэлийг улам бууруулах, гишүүдэд олгох зээлийн хүрэлцээг сайжруулах зорилгоор хэрэглээний жижиг зээлийг дагнан олгохоор төлөвлөсний дагуу ажиллаж эхэллээ.

Мөн 2016 оны 12 дугаар сараас эхлэн Ард Даатгал компанитай хамтран ажилласны дүнд 2017 оны эхээр бид гишүүдийнхээ хадгаламжийг даатгуулж анхны дүнгийн хязгааргүй даатгагдсан хадгаламжтай Хоршоо болж чадлаа. Цаашид бид гишүүддээ өөрөө удирдах боломж бүхий хурдан, шуурхай бичил банкны үйлчилгээг хүргэхээр хичээн ажиллах болно.



Хараат Бус Аудиторын Тайлан

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Тусдаа санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК ('компани' гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2016 оны 12 сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөрх жилийн тусдаа дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан тусдаа санхүүгийн тайлангууд нь компанийн 2016 оны 12 сарын 31-ний өдрийн тусдаа санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, Тусдаа Санхүүгийн Тайлан-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл ('НББЭЗОУСЗ')-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын Ёсзүйн дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НББЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт бид найдаж байна.

Аудитын Гол Асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их нөлөөтэй байсан тийм асуудлууд байна. Санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан хийсэн өөрсдийн аудитын ажил болон санхүүгийн тайлангийн талаар гаргах дүгнэлтийн хэлбэрийг тодорхойлохын аль алинд нь эдгээр асуудалд анхаарсан бөгөөд гэхдээ бид эдгээр асуудлуудын талаар тусад нь санал дүгнэлт гаргадаггүй.

1. Олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн тооцоолол АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Компани охин компаниудад оруулсан хувьцаагаарх хөрөнгө оруулалтуудыг СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр-ийн дагуу хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Энэхүү стандартын дагуу тайлант онд гарсан бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнагдана. Компани тайлант онд Ард Секюритиз ҮЦК ХХК-иар охин компаниудынхаа хувьцааны бодит үнэ цэнийн тооцооллыг хийлгэж бүртгэлд тусгасан. Үнэлгээ хийсэн компанийн тооцоолсноор охин компаниудын хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтуудын 2016 оны 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнийн нийт дүн 3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү удирдлагын тооцоолол нь тооцооллын тодорхой бус байдлын зэрэглэл өндөртэй учраас бид өөрсдийн мэргэжлийн шийдэлд үндэслэн аудитын гол асуудалд оруулсан.

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Бодит үнэ цэнийн удирдлагын тооцоололтой холбоотойгоор бид дараах арга хэмжээг авч үзсэн.Үүнд:

- Удирдлагын үнэлгээчний ур чадвар, мэргэшил, бодитой хандсан байдлыг үнэлсэн.
- Бид өөрсдийн дотоод мэдээлэл болон ур чадварт үндэслэн үнэлгээний арга хандлага, ашиглагдсан гол төсөөллүүдийн хамааралтай байдлыг үнэлсэн.
- Үнэлгээнд ашиглагдсан мэдээллийн холбоо хамаарал, үнэн зөв байдлыг түүвэрт үндэслэн шалгасан. Эцэст нь бид гол төсөөллүүд нь холбогдох нотолгоогоор хангагдаж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Бодит үнэ цэнэ болон хорогдуулалтын хувь нь бидний таамаглалтай ойролцоо байна.

2. Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээ

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Компани 2016 онд нэг компанид оруулсан хөрөнгө оруулалтаа компанийн дөрвөн хувьцаа эзэмшигчид худалдсан. Энэхүү арилжааны үнийн нэг хэсэг нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байсан Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны солилцоогоор хийгдэж, үлдсэн хэсэг нь санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгийн солилцоогоор хэрэгжсэн. Энэхүү бартерын арилжааны төлбөрт хүлээн авсан биет хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь хэлцлийн үнээр тодорхойлогдсон учраас бид өөрсдийн мэргэжлийн шийдэлд үндэслэн энэхүү хэлцлийг аудитын гол асуудалд оруулсан.

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээтэй холбоотойгоор бид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хэлцэлд оролцогч худалдагч болон худалдан авагч талууд худалдаж байгаа болон худалдан авч байгаа зүйлсийн үнэ цэнийг бодитой тодорхойлсон эсэхийг лавласан.
- Мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан барааны солилцсон үнэ нь ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн дундаж үнэтэй ойролцоо эсэхийг шинжилсэн.
- Хөрөнгийн төлбөрт гаргасан санхүүгийн хэрэгсэл нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн эсэхийг шинжилсэн.
- Худалдан авагч болон худалдагч талуудын энэхүү арилжааг хийхэд хүргэсэн дарамт шахалт байгаагүй эсэхийг магадласан. Эцэст нь бид дээрх ажил гүйлгээ холбогдох нотолгоогоор хангагдаж байна гэж үзсэн.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд тусдаа санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан багтаагүй байж болно. Тусдаа санхүүгийн тайлангийн талаар гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй. Тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь тусдаа санхүүгийн тайлан, аудитын үед олж авсан бидний ойлголт, мэдлэгээс өөрөөр материалааг буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн аудитын ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Тусдаа санхүүгийн тайланд Удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээх үүрэг хариуцлага

Тусдаа санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юмуу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголтгүй байхаас бусад тохиолдолд өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа бүх материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлнэ гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс юмуу алдаанаас үүсч болох бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа юмуу нийлбэрээрээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичигийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухай нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг. Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх

	Тэм	2016 он мян.төг	Засварласан 2015 он мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж	13	676,749	862,458
Биет бус хөрөнгө	14	17,561	-
Урт хугацаат зээлийн авлага	16	5,151,485	1,496,985
ХОЗҮХХ		-	675,148
Өмчийн хэрэглүүр	17	25,561,668	20,779,327
Нийт эргэлтийн бус хөрөнгө		31,407,463	23,813,918
Эргэлтийн хөрөнгө			
Богино хугацаат зээлийн авлага	18	159,298	1,828,751
Урьдчилгаа	19	179,439	127,526
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	15	3,000,000	-
Бараа материал		31,719	20,151
Богино хугацаат хөрөнгө оруулалт		49,791	-
Худалдааны ба бусад авлага	20	4,398,467	12,776,819
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	27	166,192	1,328,120
Нийт эргэлтийн хөрөнгө		7,984,906	16,081,367
НИЙТ ХӨРӨНГӨ		39,392,369	39,895,285
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал (Энгийн хувьцаа)	21	1,879,653	1,879,653
Халаасны хувьцаа	21	(160,216)	(160,216)
Халаасны хувьцаа -НТК		(512,084)	(512,084)
Нэмж төлөгдсөн капитал		10,441,144	10,441,144
Хуримтлагдсан ашиг		23,075,832	22,343,804
Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	22	2,707,839	-
Өмчийн бусад хэрэглүүр	23	13,799	13,799
Нийт өмч		37,445,967	34,006,100
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр төлбөр	24	352,512	-
Нийт урт хугацаат өр төлбөр		352,512	-
Эргэлтийн өр төлбөр			
Богино хугацаат зээл	25	742,335	-
Худалдааны ба бусад өр төлбөр	26	817,703	5,844,769
Орлогын албан татварын өглөг		33,852	44,416
Нийт эргэлтийн өр төлбөр		1,593,890	5,889,185
Нийт өр төлбөр		1,946,402	5,889,185

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх

	Тэм	2016 он мян.төг	Засварласан 2015 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны орлого	5	11,795,101	11,831,372
Хөрөнгө оруулалтын дансны үнэ	6	(10,013,092)	(11,684,775)
Нийт ашиг		1,782,009	146,597
Ерөнхий удирдлагын зардал	7	(1,121,650)	(880,138)
Ажиллагсадтай холбоотой зардал	8	(564,233)	(245,996)
Үйл ажиллагаанаас олсон ашиг/(алдагдал)		96,126	(979,537)
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	9	166,394	131,076
Санхүүгийн ашиг/(зардал)-цэврээр	10	842,420	222,394
Бусад олз/ (гарз)		(258,912)	(10,000)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		846,028	(636,067)
Орлогын албан татварын зардал	11	(100,042)	(53,575)
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		745,986	(689,642)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Ашиг алдагдлаар дахин ангилал хийгдэхгүй зүйлс:			
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн	22	3,010,452	-
хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт			
Хойшлогдсон татварын зардал	22	(302,613)	-
Нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)		3,453,825	(689,642)
Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал) (төгрөгөөр)			
Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)	12	44.05	(40.78)

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх

	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Халаасны хувьцааны - НТК	Нэмж төлөгдсөн капитал	Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	Хуримтлагд сан ашиг
	мян.төг	мян.төг		мян.төг	мян.төг	мян.төг
Тэмдэглэл	21	21			22	
2015 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,833,551	(154,018)	-	9,298,761	6,225,670	16,720,433
Өмнөх үеийн алдааны тохируулга	-	-	-	-	(6,225,670)	6,313,013
2015 оны 1 сарын 1-ний тохируулсан үлдэгдэл	1,833,551	(154,018)	-	9,298,761	-	23,033,446
Хувьцаа халаасласан	-	(36,577)	(512,084)	-	-	-
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	46,102	30,379	-	1,142,383	-	-
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	(689,642)
2015 оны 12 сарын 31-ээр	1,879,653	(160,216)	(512,084)	10,441,144	-	22,343,804
Нэмэгдсэн	-	-	-	-	2,707,839	-
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	745,986
Алдаа	-	-	-	-	-	(13,958)
2016 оны 12 сарын 31	1,879,653	(160,216)	(512,084)	10,441,144	2,707,839	23,075,832

Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Халаасны хувьцааны - НТК	Нэмж төлөгдсөн капитал	Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	Хуримтлагд сан ашиг	Өмчийн бусад хэрэглүүр	НИЙТ
мян.төг	мян.төг		мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
21	21			22		23	
1,833,551	(154,018)	-	9,298,761	6,225,670	16,720,433	13,799	33,938,196
-	-	-	-	(6,225,670)	6,313,013	-	87,343
1,833,551	(154,018)	-	9,298,761	-	23,033,446	13,799	34,025,539
-	(36,577)	(512,084)	-	-	-	-	(548,661)
46,102	30,379	-	1,142,383	-	-	-	1,218,864
-	-	-	-	-	(689,642)	-	(689,642)
1,879,653	(160,216)	(512,084)	10,441,144	-	22,343,804	13,799	34,006,100
-	-	-	-	2,707,839	-	-	2,707,839
-	-	-	-	-	745,986	-	745,986
-	-	-	-	-	(13,958)	-	(13,958)
1,879,653	(160,216)	(512,084)	10,441,144	2,707,839	23,075,832	13,799	37,445,967

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх

		2016 он мян.төг	Засварласан 2015 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:			
Татварын өмнөх ашиг		846,028	(636,067)
<i>Тохируулга:</i>			
Элэгдлийн зардал	13	141,598	123,773
Хүүгийн орлого		(478,909)	(41,103)
Хүүгийн зардал		107,809	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн (олз)/гарз		(89,186)	(2,320)
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз		(1,490)	
Данснаас хассан хөрөнгө		-	10,000
Хөрөнгө оруулалт худалдсан олз		-	(675,835)
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		525,850	(1,221,552)
Бараа материалын (өсөлт)/бууралт		(26,163)	(18,848)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны (өсөлт)/бууралт		74,403	(56,260)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт		10,805,792	(13,370,553)
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)		(5,750,478)	13,358,706
Үйл ажиллагаанаас олсон бэлэн мөнгө		5,629,404	(1,308,507)
Хүлээн авсан хүү		478,909	41,103
Төлсөн орлогын татвар		(57,945)	(291,000)
Мөнгөөр төлөгдсөн хүү		(79,759)	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		5,970,609	(1,558,404)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:			
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж		(10,475)	(374,930)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(15,386)	-
Худалдсан өмчийн хөрөнгө оруулалт		-	4,980,659
Худалдсан өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт		-	45,000
Худалдсан ТБҮЦ		-	22,760
Худалдан авсан өмчийн хөрөнгө оруулалт		(5,021,643)	(144,661)
Олгосон зээл		(4,638,553)	(2,442,622)
Олгосон зээлийн эргэн төлөлт		1,781,523	602,848
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		(7,904,534)	2,689,054
САНХҮҮЖИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:			
Авсан зээл		1,760,000	
Зээлийн эргэн төлөлт		(1,018,271)	(211,000)
САНХҮҮЖИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		741,729	(211,000)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ бууралт		(1,161,928)	919,650
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү		30,268	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27	1,328,120	408,470
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27	166,192	1,328,120

Хараат Бус Аудиторын Тайлан

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болон түүний охин компаниудыг багтаасан группийн (‘Групп’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2016 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөрх жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласнаас бусад бүх материаллаг талаараа хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группын 2016 оны 12 сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Компани 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнөх хугацаанд худалдан авч нэгтгэсэн хараат болон охин компаниудын худалдан авалтыг СТОУС 3, Бизнесийн нэгдэлд заасны дагуу тодорхойлогдох хөрөнгө, хүлээж болох өр төлбөр, цөөнхийн оролцоо зэргийн бодит үнэ цэнийг олж эзэмшсэн өдрөөр хэмжиж, гүүдвилийг тооцоолоогүй, хөрөнгө өр төлбөрийн дансны үнэд суурилан гүүдвилийг тооцоолсон байна. Бид аудитын явцад эдгээр нэгдлүүдийн өдрөөрх гүүдвилийг үнэн зөв тооцоолох боломжгүй байсан. Мөн Тэмдэглэл 21, Гүүдвил-д тусгагдсан 5,488,568 мянган төгрөг (2014: 5,128,272 мян.төг)-ийн гүүдвилд тайлант жилийн эцсээр аливаа үнэ цэнийн бууралтад орсон эсэх талаар тест хийж баримтжуулаагүй бөгөөд аудитуудыг гүүдвилийн үнэ цэнэ буураагүй гэсэн зохистой бөгөөд хангалттай нотолгоогоор хангаагүй.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (‘НББЭЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрэм болон Монгол Улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НББЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт бид найдаж байна.

Аудитын Гол Асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их нөлөөтэй байсан асуудлууд байдаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан хийсэн өөрсдийн аудитын ажил болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар гаргах дүгнэлтийн хэлбэрийг тодорхойлохын аль алинд нь эдгээр асуудалд анхаарсан боловч бид эдгээр асуудлуудын талаар тусад нь санал дүгнэлт гаргадаггүй.

1. Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээ

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Групп 2016 онд нэг компанид оруулсан хөрөнгө оруулалтаа компанийн дөрвөн хувьцаа эзэмшигчдэд худалдсан. Энэхүү арилжааны үнийн нэг хэсэг нь тухайн хувьцаа эзэмшигч нарын эзэмшиж байсан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны солилцоогоор хийгдэж, үлдсэн хэсэг нь санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгийн солилцоогоор хэрэгжсэн. Энэхүү бартерын арилжааны төлбөрт хүлээн авсан биет хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь хэлцлийн үнээр тодорхойлогдсон учраас бид өөрсдийн мэргэжлийн шийдэлд үндэслэн энэхүү хэлцлийг аудитын гол асуудалд оруулсан.

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээтэй холбоотойгоор бид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хэлцэлд оролцогч худалдагч болон худалдан авагч талууд худалдаж байгаа болон худалдан авч байгаа зүйлсийн үнэ цэнийг бодитой тодорхойлсон эсэхийг лавласан.
- Мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан барааны солилцсон үнэ нь ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн дундаж үнэтэй ойролцоо эсэхийг шинжилсэн.
- Хөрөнгийн төлбөрт гаргасан санхүүгийн хэрэгсэл нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн эсэхийг шинжилсэн.
- Худалдан авагч болон худалдагч талуудын энэхүү арилжааг хийхэд хүргэсэн дарамт шахалт байгаагүй эсэхийг магадалсан. Эцэст нь бид дээрх ажил гүйлгээ холбогдох нотолгоогоор хангагдаж байна гэж үзсэн.

2. Даатгалын нөөц сангийн тооцоолол

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Ердийн даатгалын нөөц санг гэдэгт доорх нөөц сангууд багтана. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) гэдэгт тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН) гэдэгт даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсгийг ойлгоно. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС) гэдэгт даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдсэн болон төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно. Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХБТБНС) гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно. Группын охин компани болох Ард Даатгал компани нь СЗХ-оос батлагдсан шинэ журмыг хэрэгжүүлж 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт 4,355,185 мянган төгрөгийн нөөц сантай байна. Даатгалын нөөц сангийн тооцоолол нь мэргэжлийн актуар тооцоолол ашиглахыг шаарддаг учир тооцоолол болон хэмжилтэд алдаа гарах эрсдэл байна гэж үзсэн.

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Бид нөөцийн сангийн тооцоолол болон хүлээн зөвшөөрөлтийг хамрах голлох дотоод хяналтын тогтолцоо, процессыг үнэлж шалгасан. Мөн бид аудитын ажилдаа хөндлөнгийн хараат бус, хангалттай ур чадвар бүхий аудиторын экспертийн ажлыг ашиглан даатгалын нөөц сангийн тооцооллыг шалгуулсан. Манай хөндлөнгийн актуарын эксперт нь нөөцийн сангийн тооцоололд ашигласан өгөгдлүүдийн ул үндэслэлтэй байдал, арифметик тооцоолол үнэн зөв эсэхийг шинжилжээ, дахин тооцоолол болон зарим биет горимуудыг гүйцэтгэн шалгасан.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан багтаагүй байж болно. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, аудитын үед олж авсан бидний ойлголт, мэдлэгээс өөрөөр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн аудитын ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь Группыг татан буулгах юмуу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголтгүй байхаас бусад тохиолдолд өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх Группын чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Төлөөлөн удирдах зөвлөл нь Группын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа бүх материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлнэ гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс юм уу алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа юмуу нийлбэрээрээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичигийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Группын дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухай нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.

· Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.

· Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

БДО Аудит ХХК Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО гудамж, Нарны зам-62
ЮНИОН Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2017.5.5

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	Тэм	2016 он мян.төг	Засварласан 2015 он мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бүс хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	18	1,365,479	2,738,772
Биет бүс хөрөнгө - цэвэр	19	52,416	44,109
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	20	1,894,933	675,148
Гүүдвил	21	5,488,569	5,128,272
Урт хугацаат зээлийн авлага	22	5,038,698	1,496,985
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө	23	821,781	-
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	25	1,230,413	1,115,914
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	26	7,925,538	2,531,446
Нийт эргэлтийн бүс хөрөнгө		23,817,827	13,730,646
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	24	3,097,600	-
		26,915,427	13,730,646
Эргэлтийн хөрөнгө			
Бусад эргэлтийн хөрөнгө			
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	27	829,867	621,702
Бараа материал	28	64,329	31,111
Богино хугацаат зээлийн авлага	29	4,378,686	4,296,316
Худалдааны болон бусад авлага	30	2,397,641	9,254,891
Бусад богино хугацаат санхүүгийн хөрөнгө	31	1,005,045	146,872
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43	3,610,491	7,485,551
Нийт эргэлтийн хөрөнгө		12,286,059	21,836,444
НИЙТ ХӨРӨНГӨ		39,201,486	35,567,090

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	Тэм	2016 он мян.төг	Засварласан 2015 он мян.төг
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал	32	1,879,653	1,879,653
Нэмж төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа	33	10,400,013	10,400,013
Халаасны хувьцаа	32	(471,579)	(522,791)
Нэмж төлөгдсөн капитал - Халаасны хувьцаа		(6,144,347)	(5,547,966)
Өмчийн бусад хэсэг	34	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг, алдагдал		22,672,884	13,658,043
Хяналтын бус хувь оролцоо	35	1,058,351	2,489,496
Нийт өмч		29,408,774	22,370,247
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	36	200,000	429,343
Санхүүгийн түрээсийн өглөг	37	110,127	-
Хойшлогдсон татварын өр	38	56,038	3,467
Урт хугацаат өр төлбөр		366,165	432,810
Богино хугацаат өр төлбөр			
Худалдааны болон бусад өглөг	39	3,758,688	7,644,738
Эрсдэлийн нөөц	40	1,343,182	1,370,658
Орлогын татварын өглөг		97,083	86,700
Урт хугацаат санхүүгийн түрээсийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	37	31,326	-
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	36	20,406	11,976
Богино хугацаат зээл	41	1,154,501	486,564
Урьдчилж орсон орлого	42	3,021,361	3,163,397
Нийт богино хугацаат өр төлбөр		9,426,547	12,764,033
Нийт өр төлбөр		9,792,712	13,196,843
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		39,201,486	35,567,090

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	Тэм	2016 он мян.төг	2015 он мян.төг
Борлуулалтын орлого – цэвэр	6	19,324,115	19,446,549
Борлуулалтын өртөг	7	(5,573,443)	(5,651,257)
Нийт ашиг		13,750,672	13,795,292
Цалин хөлс, түүнтэй адилтгах зардал	8	(2,576,487)	(1,880,726)
Ерөнхий удирдлагын зардал	9	(3,399,495)	(3,552,032)
Үйл ажиллагааны ашиг		7,774,690	8,362,534
Санхүүгийн орлого/(зардал)	10	1,654,196	968,341
Борлуулах зорилготой санхүүгийн хөрөнгийн үнэлгээний олз/гарз		1,376	(75)
Хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	11	394,126	187,263
Бусад орлого/(зардал)	12	(80,975)	238,321
Бусад олз/(гарз)	13	(335,752)	(172,228)
Татвар төлөхийн өмнөх ашиг		9,407,661	9,584,156
Орлогын татварын зардал	14	(230,000)	(166,381)
Хэвийн үйл ажиллагаанаас олсон ашиг		9,177,661	9,417,775
Зогсоосон үйл ажиллагаанаас олсон ашиг	15	-	9,802
Тайлант жилийн цэвэр ашиг		9,177,661	9,427,577
Хяналтын бус хувь оролцооны зардал	16	(136,916)	(59,444)
Группын цэвэр ашиг		9,040,745	9,368,133
Нэгж хувьцаанд ногдох ашиг	17	658	555

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	2016 он мян.төг	2015 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	9,407,661	9,584,156
ТӨА-ийн тохируулга:		
Өмч барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	224,386	248,190
Биет бус хөрөнгийн хорогдуулга	-	11,060
БҮТЭЗ-ийн хорогдуулга	13,455	2,476
Хараат компанийн (ашиг)/алдагдлын ногдох хэсэг	(394,126)	(187,263)
Эрсдэлийн нөөцийн зардал	131,478	69,400
Найдваргүй авлагын зардал	3,099	71,666
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз/(олз)	264,641	126,373
Бараа материал данснаас хассан гарз/(олз)	-	7,844
Хараат компани худалдсаны гарз/(олз)	(7,205,197)	-
Зогсоосон үйл ажиллагааны алдагдал/(ашиг)	-	9,802
Хөрөнгө оруулалт данснаас хассаны гарз/(олз)	-	10,000
Охин компанийн худалдан авалтын үеийн олз	-	(38,415)
Ханшийн зөрүүгийн гарз/(олз)	(452,682)	-
Ногдол ашгийн орлого	-	(50,002)
Хүүгийн орлого	(1,610,034)	(2,032,460)
Хүүгийн зардал	113,239	369,540
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	495,920	8,202,367
Ажлын капиталын өөрчлөлт:		
Бусад эргэлтийн хөрөнгийн бууралт/(өсөлт)	-	(3,096)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны бууралт/(өсөлт)	(212,515)	46,535
Бараа материалын бууралт/(өсөлт)	(33,218)	(5,283)
Зээлийн авлагын бууралт/(өсөлт)	2,185,177	(2,994,176)
Худалдааны болон бусад авлагын бууралт/(өсөлт)	6,757,005	(6,515,603)
Худалдааны болон бусад өглөг өсөлт/(бууралт)	(7,520,240)	6,675,721
Эрсдэлийн нөөцийн өсөлт/(бууралт)	(27,474)	(207,714)
Урьдчилж орсон орлогын өсөлт/(бууралт)	(142,037)	651,155
Бусад эргэлтийн өр төлбөрийн өсөлт/(бууралт)	(34)	(137,313)
Үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ	1,502,584	5,712,593
Төлсөн орлогын татвар	(167,012)	(391,249)
Хүүгийн төлөлт	-	(339,174)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,335,572	4,982,170

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	2016 он мян.төг	2015 он мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(1,046,023)	(2,341,871)
Худалдсан борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	146,872	1,740,211
Бусдад олгосон зээл	(3,269,258)	-
Бусдад олгосон зээлийн эргэн төлөлт	907,329	-
Оруулсан хөрөнгө оруулалт	(4,939,420)	(139,466)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(362,322)	(126,098)
Худалдсан өмч, барилга, тоног төхөөрөмж	555,848	373,973
Худалдаж авсан биет бус хөрөнгө	(15,386)	(100)
Худалдаж авсан дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт	(771,991)	-
Хүлээн авсан ногдол ашгийн орлого	-	50,002
Хүлээн авсан хүүгийн орлого	1,575,978	1,987,240
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,218,373)	1,543,891
САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Эргэлтэд гаргасан хувьцаа	3,083,009	1,218,864
Худалдаж авсан халаасны хувьцаа	-	(5,944,247)
Хяналтын бус хувь оролцоо	(1,568,060)	(254,923)
Авсан зээл	1,740,650	715,653
Зээлийн төлөлт	(1,247,858)	(717,059)
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,007,741	(4,981,712)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,875,060)	1,544,349
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43 7,485,551	5,941,202
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43 3,610,491	7,485,551

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хаалттай Хувьцаат Компани

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

	Хувьцаат капитал	төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	төлөгдсөн капитал - Халаасны хувьцаа
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
	32	33	32	
2015 оны 1 сарын 1-ээр	1,833,551	9,257,629	(156,887)	-
Хувьцаа халаасалсан	-	-	(396,283)	(5,547,966)
ЭЗИТБ-ын нөлөө	-	-	-	-
Эргэлтэд гаргасан халаасны хувьцаа	46,102	1,142,384	30,379	-
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант жилийн ашиг	-	-	-	-
2015 оны 12 сарын 31-ээр	1,879,653	10,400,013	(522,791)	(5,547,966)
Хувьцаа халаасалсан	-	-	(311,363)	(5,673,395)
Тайлант оны алдаа	-	-	-	-
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-
Эргэлтэд гаргасан халаасны хувьцаа	-	-	362,575	5,077,014
Тайлант жилийн ашиг	-	-	-	-
2016 оны 12 сарын 31-ээр	1,879,653	10,400,013	(471,579)	(6,144,347)

Хуримтлагдсан ашиг	Өмчийн бусад хэрэглүүр	Группэд хамаарах өмчийн дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт өмч
мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
	34		35	
4,202,566	13,799	15,150,659	2,684,975	17,835,634
-	-	(5,944,249)	-	(5,944,249)
87,344	-	87,344	-	87,344
-	-	1,218,864	-	1,218,864
-	-	-	(109,286)	(109,286)
-	-	-	(145,637)	(145,637)
9,368,133	-	9,368,133	59,444	9,427,577
13,658,043	13,799	19,880,751	2,489,496	22,370,247
-	-	(5,984,758)	-	(5,984,758)
(25,904)	-	(25,904)	-	(25,904)
-	-	-	(1,568,061)	(1,568,061)
-	-	5,439,589	-	5,439,589
9,040,745	-	9,040,745	136,916	9,177,661
22,672,884	13,799	28,350,423	1,058,351	29,408,774

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн
байгууллага



Хадгаламж зээлийн
хоршоо



Брокер, диллер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Хөрөнгө
оруулалтын менежмент



Тэтгэврийн сан



Шуудангийн
Цогц Шийдэл



Үл хөдлөх хөрөнгийн
түрээс



Санхүүгийн програм
хангамж



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН**

Хөрөнгө
оруулалтын сан



📍 “Ард Холдингс”-н байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс

📄 цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

📞 (+976) 7707 8080

📠 (+976) 7707 8080

✉ info@ardholdings.com

🌐 www.ardholdings.com